



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 1д өдөр

Дугаар А/11

Булган

Г 2021 оныг “Үндэсний өв, бичиг, соёлыг”
түгээн дэлгэрүүлэх” жил болгон
зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2021 оныг “Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх” жил болгон зарласугай.

2. Жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, болзол журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх” жилийн ажлыг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орон тооны бус зөвлөх /Д.Чимгээ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

20210022

Аймгийн Засаг даргын 2021 оны 01
дугаар сарын 12-ны өдрийн тоот
захирамжийн нэгдүгээр
хавсралт

**“Үндэсний өв, бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх” жилийн ажлыг зохион
байгуулах ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Чимгээ -Аймгийн Засаг даргын орон тооны бус зөвлөх

Гишүүд:

Д.Алтаншагай- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Отгонсүвд- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн

М.Батжаргал- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын
албаны ажилтан

Э.Түвшинмөнх- Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Л.Намуунтуяа-Боловсрол, соёл урлагийн газрын Монгол хэлний
сургалт хариуцсан мэргэжилтэн

Т.Дэлгэрмаа-Насан туршийн боловсролын төвийн захирал

Г.Баярчимэг-Булган сумын 1-дүгээр сургуулийн Монгол хэлний
багш

Д.Дарьсүрэн-Урлаг дизайны академийн тэргүүн

А.Наранцэцэг-Ахмад багш

Д.Баярсайхан - Аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн
холбооны дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Оюунбилэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2021 оны 01
дугаар сарын 11-ны өдрийн тоот
захирамжийн хоёрдугаар
хавсралт

“ҮНДЭСНИЙ ӨВ, БИЧИГ, СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ” ЖИЛИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн, албан ёсны дэлхийн бичиг соёлын нандин өв юм.

Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг мөн.

Манай улс 1941 оноос хойш төрийн албан хэргийг кирилл бичгээр хөтлөн явуулж байгаа ч төрийн байгууллагын тамга, тэмдгийг монгол бичгээр үйлдэн хэрэглэж, иргэний болон боловсролын бичиг баримтыг кирилл болон монгол бичгээр зэрэгцүүлэн бичиж байгаа нь монгол бичиг төрийн хэрэгт зохих үүргээ гүйцэтгэсээр байгаагийн нэгэн бодит жишээ билээ.

Өнөөгийн үндэсний бичгийн сургалт, хэрэглээний байдлаас үзвэл цаашид сургалтыг насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэн, уялдуулах нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор “**Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III**”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд түүний 3.3.7 дахь заалтад төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх, Монгол хэлний тухай хуулийн 24-ийн 7.2 дахь хэсэгт 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах тухай заасан.

Иймд “Хос бичигтэн” болох бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд хангах, үндэсний бичигт суралцах, мэдлэг, чадвараа ахиулах, бичиг, соёлыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага нь уг жилийн ажлыг зохион байгуулах үндэслэл болно.

ХОЁР. ЗОРИЛГО

Үндэсний өв, бичиг, соёлыг сурталчлан, түгээн дэлгэрүүлж, үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн албан хэргийг 2025 оноос эхлэн хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан бэлтгэл ажлыг аймгийн хэмжээнд хангахад оршино.

ГУРАВ. ЗОРИЛТ

- 3.1 Мэдлэг чадварыг дээшлүүлэх;
- 3.2 Үндэсний бичгийн орчин бүрдүүлэх;
- 3.3 Хэрэглээг нэмэгдүүлэх;
- 3.4 Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах;
- 3.5 Үндэсний бичгийн сургалт сурталчилгаа, түгээн дэлгэрүүлэх;

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Булган аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт байгууллагууд /өмчийн хэлбэр харгалзахгүйгээр/ иргэд, суралцагчид

ТАВ. ХУГАЦАА

2021 оны 01 дүгээр сарын 06-наас 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл

ЗУРГАА. ЖИЛИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 6.1. Сум, байгууллага бүр жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, хөтөлбөр төлөвлөгөө гарган, удирдлага зохион байгуулалт хийсэн байх;
- 6.2. Байгууллагын бүх удирдлага, албан хаагчдаас “Үндэсний бичиг”-ийн мэдлэгийн гарааны судалгаа авч, улирал бүр ахицыг нь үнэлэх;
- 6.3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар тусган, ахицын түвшингээр үр дүнгийн урамшуулал олгох;
- 6.4. Сум бүр баг, хороо, гудамжны хаяг нэр, бэлгэ тэмдэг /лого/ нутаг дэвсгэрийн зааг дахь самбар зэргийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан алдаагүй бичих ажлыг зохион байгуулах;
- 6.5. Албан байгууллага бүр байгууллагын хаяг, бэлгэ тэмдэг /лого/, нэрийн хуудас, ажлын баримт бичгийн хавтасны нэрийг үндэсний бичгээр хаягжуулах;
- 6.6. Байгууллага, хамт олноороо “Үндэсний бичигтэн” болох аян, хөдөлгөөн өрнүүлэх;
- 6.7. Насан туршийн боловсролын төв, нэгжээр дамжуулан зохион байгуулж буй сургалтад хамрагдаж, мэдлэг, чадвараа ахиулах;
- 6.8. Цахим хэрэглээний чадварт суралцах, орчин бүрдүүлсэн байх;
- 6.9. “Үндэсний бичигтэн сум, байгууллага”, “Үндэсний бичигтэн төрийн албан хаагч”, “Үндэсний бичигтэн иргэн”, үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш нар”-ын баг, үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш” шалгаруулж урамшуулах;
- 6.10. “Үндэсний бичиг-Бидний бахархал” тэмцээн зохион байгуулах;
- 6.11. Үндэсний бичгийн “Түргэн уншигч-2021” уралдаан зохион байгуулах;
- 6.12. “Сайхан бичигтэн” уралдаан зохион байгуулах;
- 6.13. “Үндэсний бичиг заах арга зүй, урлан бүтээх” уралдаан зохион байгуулах;
- 6.14. Монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжин сурталчлах;
- 6.15. “Хүмүүн бичиг” сониныг захиалах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, сурталчлах;
- 6.16. Үндэсний бичиг, биет бус өв, соёл, түүхийн дурсгалыг судлан сурталчлах

ДОЛОО. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 7.1. Үндэсний бичгээр “Анхан шат”-ны унших чадварыг 40, бичих чадварыг 30 хувьд хүргэнэ.
- 7.2. Үндэсний бичгээр “Дунд шат”-ны унших чадварыг 60, бичих чадварыг 40 хувьд хүргэнэ.
- 7.3. Сургагч багшийн тоог 120-оор нэмэгдүүлнэ.
- 7.4. Сургагч багш нарын 20 багтай болно.
- 7.5. Байгууллагын дотоод албан бичгийг кирилл, үндэсний бичгээр хослуулан бичиж сурах хэрэглээг 25 хувьд хүргэнэ.
- 7.6. Цахим орчинд үндэсний бичгээр аливаа бичиг баримтыг боловсруулж ажлын хэрэглээг 10 хувьд хүргэнэ.
- 7.7. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр

хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичсэн хаягжилтыг 50 хувьд хүргэнэ.

НАЙМ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДҮГНЭХ

- 8.1. Жилийн ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс болон Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл хариуцна.
- 8.2. Жилийн ажлын тайланг хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.
- 8.3. Сумын Засаг даргын Тамгын газар нь орон нутгийн хэмжээнд жилийн ажлыг зохион байгуулж удирдлага, арга зүйгээр хангана.
- 8.4. Ажлын хэсэг тайлан мэдээг 3, 6, 9, 10 дугаар сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.
- 8.5. Сум, агентлаг байгууллага, иргэд жилийн ажлын хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн, тайланг үнэлэн, шагнаж урамшуулна.

ЕС. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

“Үндэсний бичигтэн сум”

- 1-р байр Өргөмжлөл, 5 сая
- 2-р байр Өргөмжлөл, 3 сая
- 3-р байр Өргөмжлөл, 1 сая

“Үндэсний бичигтэн байгууллага”

- 1-р байр Өргөмжлөл 3, сая
- 2-р байр Өргөмжлөл 2, сая
- 3-р байр Өргөмжлөл 1, сая

Үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш нар”-ын баг

- 1-р байр Өргөмжлөл, 2 сая
- 2-р байр Өргөмжлөл, 1 сая
- 3-р байр Өргөмжлөл, 500.0

Үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш”

- 1-р байр Өргөмжлөл, 1 сая
- 2-р байр Өргөмжлөл, 700.0
- 3-р байр Өргөмжлөл, 500.0

Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч” /анхан, дунд/

- 1-р байр Өргөмжлөл 1 сая
- 2-р байр Өргөмжлөл 700.0
- 3-р байр Өргөмжлөл 500.0

“Үндэсний бичигтэн иргэн” /анхан, дунд/

- 1-р байр Өргөмжлөл 1 сая
- 2-р байр Өргөмжлөл 700.0
- 3-р байр Өргөмжлөл 500.0

“Үндэсний бичиг заах арга зүй, урлан бүтээх” уралдаан

- 1-р байр Өргөмжлөл 500.0
- 2-р байр Өргөмжлөл 300.0
- 3-р байр Өргөмжлөл 200.0

ЕС. ЖИЛИЙН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

	Үзүүлэлт	Үнэлгээ
1.	Сум, байгууллага бүр жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилон, хөтөлбөр төлөвлөгөө гарган, удирдлага зохион байгуулалт хийсэн байх	2
2.	Байгууллагын бүх удирдлага, ажилтан, албан хаагчдаас “Үндэсний бичиг”-ийн мэдлэгийн гарааны судалгаа авч, улирал бүр ахицыг нь үнэлэх	5
3.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар тусган, ахицын түвшингээр үр дүнгийн урамшуулал олгох	5

4.	Сум бүр баг, хороо, гудамжны хаяг нэр, бэлгэ тэмдэг /лого/ нутаг дэвсгэрийн зааг дахь самбар зэргийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан алдаагүй бичих ажлыг зохион байгуулах	5
5.	Албан байгууллага бүр байгууллагын хаяг, бэлгэ тэмдэг /лого/, нэрийн хуудас, ажлын баримт бичгийн хавтасны нэрийг үндэсний бичгээр хаягжуулах	3.5
6.	Байгууллага, хамт олноороо “Үндэсний бичигтэн” болох аян, хөдөлгөөн өрнүүлэх	4.5
7.	Насан туршийн боловсролын төв, нэгжээр дамжуулан зохион байгуулж буй сургалтад хамрагдаж, мэдлэг, чадвараа ахиулах;	13
8.	Цахим хэрэглээний чадварт суралцах, орчин бүрдүүлсэн байх	10.5
9.	“Үндэсний бичигтэн сум, байгууллага”, “Үндэсний бичигтэн төрийн албан хаагч”, “Үндэсний бичигтэн иргэн”, үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш нар”-ын баг, үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш” шалгаруулж урамшуулах;	Удирдамжид заасан шалгуураар
10.	“Үндэсний бичиг-Бидний бахархал” тэмцээн зохион байгуулах	10
11.	Үндэсний бичгийн “Түргэн уншигч-2021” уралдаан зохион байгуулах	10
12.	“Сайхан бичигтэн” уралдаан зохион байгуулах	10
13.	“Үндэсний бичиг заах арга зүй, урлан бүтээх” уралдаан зохион байгуулах	Удирдамжид заасан шалгуураар
14.	Монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих, сурталчлах	1.5
15.	“Хүмүүн бичиг” сониныг захиалах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, сурталчлах;	10
16.	Үндэсний бичиг, биет бус өв, соёл, түүхийн дурсгалыг судлан сурталчлах	10
Нийт		100

**АРАВ. “ҮНДЭСНИЙ ӨВ, БИЧИГ, СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ”
ЖИЛИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ**

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
1.	Сум, байгууллага бүр жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилон, хөтөлбөр төлөвлөгөө гарган, удирдлага зохион байгуулалт хийсэн байх / 4.5 оноо /	Зохион байгуулах ажлын хэсгийг сум, байгууллагын удирдлагын албан шийдвэрээр томилон үйл ажиллагаа явуулж буй бол 0,5 оноо Ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж үр дүнг тооцон ажиллаж буй бол 2 оноо Улирал бүр тайланг хугацаанд явуулсан бол 2 оноо , хугацаа хоцорсон бол 1 оноо , ирүүлээгүй бол 0	
2.	Байгууллагын бүх удирдлага, албан хаагчдаас үндэсний бичгийн мэдлэгийн гарааны судалгаа авч, улирал бүр ахицыг нь үнэлэх / 5 оноо /	Үндэсний бичгийн унших, бичих чадварын гарааны судалгаанд байгууллагын албан хаагчдыг 100 хувь хамруулсан бол 2 оноо 1 хүн хамруулаагүй бол 0,1 оноо хасаж үнэлнэ. Ахицын судалгаа 3 оноо Байгууллагын албан хаагчдын 80-аас дээш хувь нь ахисан бол 3 оноо , 70-аас дээш хувь нь ахисан бол 2	

		ОНОО , 60-аас дээш хувь нь ахисан бол 1 ОНОО Оролцоогүй хүний тоогоор 0.1 ОНОО хасна.	
3.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар тусган, ахицын түвшнээр үр дүнгийн урамшуулал олгох /2.5 ОНОО/	Ахицын судалгаанд үндэслэн урамшуулал олгосон бол 2.5 ОНОО Олгоогүй бол 0 ОНОО	
4.	Сум бүр баг, хороо, гудамжны хаяг нэр, бэлгэ тэмдэг /лого/ нутаг дэвсгэрийн зааг дахь самбар зэргийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан алдаагүй бичих ажлыг зохион байгуулах /5 ОНОО/	Баг, хороо, гудамжны хаяг нэр, бэлгэ тэмдэг /лого/ нутаг дэвсгэрийн зааг дахь самбарыг 100 хувь хаягжуулж хос бичгээр бичсэн бол 5 ОНОО , 90 хувь бол 4 ОНОО , 80 хувь бол 3 ОНОО , 70 хувь бол 2 ОНОО , 60 хувь бол 1 ОНОО Алдаа болгоноос 0,1 ОНОО хасаж үнэлнэ.	
5.	Албан байгууллага бүр байгууллагын хаяг, бэлгэ тэмдэг /лого/, нэрийн хуудас, ажлын баримт бичгийн хавтасны нэрийг үндэсний бичгээр хаягжуулах /3.5 ОНОО/	Хаяг, бэлгэ тэмдэг /лого/, нэрийн хуудас тус бүр 0.5 ОНОО /Нийт 1.5 ОНОО/ Дутуу буюу алдаатай тохиолдолд 0.1 ОНОО хасна. Байгууллагын албан хаагч, ажилтан бүр өөрийн ажлын баримт бичгийн хавтасны нэрийг үндэсний бичгээр хаягжуулах /2 ОНОО/ Дутуу буюу алдаатай тохиолдолд 0.5 ОНОО хасаж үнэлнэ.	
6.	Сум, байгууллагын хамт олон “Үндэсний бичиг”-ийн орчин бүрдүүлэх /4.5 ОНОО/ Үндэсний бичиг судлах ном, гарын авлагатай болох /1 ОНОО/ Хүн бүр монгол хэл, үндэсний бичгийн толиудын application гар утсандаа суулгаж хэрэглэх /1.5 ОНОО/ Мэдээллийн самбар, зар сурталчилгааг үндэсний бичгээр бичих /2 ОНОО/	Үндэсний бичиг судлах ном, гарын авлагаар сурах орчин бүрдүүлсэн бол 1 ОНОО Орчин бүрдүүлээгүй бол 0 ОНОО “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”, “Их Монгол толь”, “Тайлбар толь”-ийн application гар утсандаа суулган хэрэглэж хэвших Хэрэглээ болгосон бол 1.5 ОНОО Мэдээллийн самбар, зар сурталчилгааг үндэсний бичгээр бичих 1 ОНОО өгнө. Мэдээллийн самбарт зар сурталчилгааг сард 1 удаа, нийт 8-аас доошгүй удаа үндэсний бичгээр бичиж хэвшсэн бол 2 ОНОО Дутуу буюу алдаатай тохиолдолд 0,2 ОНОО хасаж үнэлнэ.	
7.	Байгууллага хамт олноороо “Үндэсний бичигтэн” болох аянд оролцож, Насан туршийн боловсрол төв, нэгжээр дамжуулан сургалт зохион байгуулан мэдлэг, чадвараа ахиулах /13 ОНОО/ Сургалт зохион байгуулсан байгууллагын тоо /3 ОНОО/ Сургалтад суралцсан хүний тоо /2 ОНОО/ Сургалтад суралцсан суралцагчдын ахиц /5 ОНОО/ “Сургагч багшийн батламж” авч бусдад тусалсан хүний тоо /3 ОНОО/	Нэг байгууллага аяны хугацаанд 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан бол 3 ОНОО Дутуу тохиолдолд 0.5 ОНОО хасна. Зохион байгуулсан сургалтад байгууллагын бүх хүн 100 хувь суралцсан бол 2 ОНОО 10 хувь буурах тутамд 0.1 ОНОО хасна. Сургалтад суралцсан суралцагчдын ахицыг 8 удаагийн уншлага, бичлэгийн дунджаар гаргаж, гарааны судалгаанаас ахицыг тооцно. Анхан шатны суралцагч жилийн эцэст минутад 50 үг уншиж, 30 үгийг	

		<p>зөв бичвэл 5 оноо</p> <p>Дутуу уншсан, бичсэн үг болгоноос 0.1 оноо хасаж тооцно.</p> <p>Дунд шатны суралцагч жилийн эцэст минутад 150-аас дээш үг уншиж, 60 үгийг зөв бичвэл 5 оноо</p> <p>Дутуу уншсан, бичсэн үг болгоноос 0.1 оноо хасна.</p> <p>Анхан болон дунд шатны сургалтад идэвхтэй сайн суралцсан тус бүр 1 хүн “Сургагч багш”-ийн батламж авна. Анхны шатны сургагч багшийн “Батламж” авсан хүн 5, дунд шатны сургагч багшийн “Батламж” авсан хүн 10 хүнд үндэсний бичгийн сургалтыг зохион байгуулан, уншуулж, бичүүлж сургана.</p> <p>Уншуулж, бичүүлж сургасан хүний тоогоор 0.5 оноо өгнө.</p>	
8.	<p>Цахим хэрэглээний чадварт суралцах /10,5 оноо/</p> <p>Монгол бичгийн фонд суулгах /0.5 оноо/</p> <p>Цахим сургалт буюу бие даан суралцан /Chimee App, Sms Huree, Sms Ulaanbaatar, Mongolian bati програмуудыг эзэмшин хэрэглээ болгосон байх/ /10 оноо/</p>	<p>Монгол бичгийн фонд суулгасан бол 0,5 оноо</p> <p>Анхан шатны суралцагч 7 хоногт 1 удаа Chimee хэрэглүүрийг ашиглан “МОНГОЛ БИЧИГ БУЛГАН АЙМАГ” нүүр номын бүлгэмд жилдээ 32 зурвасыг байршуулсан бол 10 оноо</p> <p>Дутуу зурвас тутамд 0.5 оноо хасаж үнэлнэ.</p> <p>Дунд шатны суралцагч Chimee App, CMs Huree, CMs Ulaanbaatar, Mongolian bati програмуудыг эзэмшсэн бол 4 оноо</p> <p>Дутуу эзэмшсэн бол 1 оноо хасаж үнэлнэ.</p> <p>“МОНГОЛ БИЧИГ БУЛГАН АЙМАГ” нүүр номын бүлгэмд 7 хоногт 2 удаа жилдээ 64 бичвэр /зурвас, мэндчилгээ, талархал, зөвлөмж, туршлага, эсээ гэх мэт/ байршуулсан бол 6 оноо</p> <p>Дутуу бичвэр тутамд 0.5 оноо хасаж үнэлнэ.</p>	
9.	<p>“Үндэсний бичигтэн сум, байгууллага”, “Үндэсний бичигтэн төрийн албан хаагч”, “Үндэсний бичигтэн иргэн”, үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш нар”-ын баг, үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш” шалгаруулж урамшуулах;</p>	<p>Удирдамжид заасан шалгуураар</p>	
10.	<p>“Үндэсний бичиг-Бидний бахархал” тэмцээн зохион байгуулах /20 оноо/</p> <p>Байгууллага дотроо дээрх тэмцээнийг зохион байгуулж хамт олноо оролцуулсан байх /5.5 оноо/</p> <p>Байгууллагаас шалгарсан багийг сумын тэмцээнд бэлтгэн оролцуулах /4,5 оноо/</p> <p>Үндэсний бичиг, биет бус өв, соёл, түүхийн дурсгалыг судлан сурталчлах /10 оноо/</p>	<p>Бүх хүмүүсээ баг болгож “Үндэсний бичиг бидний бахархал” тэмцээнд 100 хувь оролцуулсан бол 5.5 оноо 10 хувь буурах тутамд 1 оноо хасна.</p> <p>Байгууллагаас шалгарсан багийг сумын тэмцээнд оролцож</p> <p>I байр эзэлсэн бол 2 оноо</p> <p>II байр эзэлсэн бол 1,5 оноо</p> <p>III байр эзэлсэн бол 1 оноо</p> <p>Үндэсний бичиг, биет бус өв, соёл, түүхийн дурсгалыг судлан сурталчлах /Удирдамжид заасан шалгуураар/ 10 оноо</p>	
11.	<p>Үндэсний бичгийн “Түргэн уншигч-2021” уралдаан зохион</p>	<p>Бүх хүмүүсийг байгууллагын тэмцээнд оролцуулсан бол 5 оноо</p>	

	<p>байгуулах /10 оноо/ Байгууллагын бүх албан хаагчдыг “Түргэн уншигч-2021” уралдаанд оролцуулах</p> <p>/5 оноо/ Байгууллагаас шалгарсан багийг сумын тэмцээнд бэлтгэн оролцуулах</p> <p>/2 оноо/ Сумаас шалгарсан багийг аймгийн тэмцээнд бэлтгэн оролцуулах/ 3 оноо/</p>	<p>Үнэлгээг хийхдээ дармал, бичмэл 2 эх уншуулна. Зөв уншсан үгийн нийлбэр тоог унших үгийн тоонд хувааж хувийг гаргана. Жич: 40 үгтэй 2 эхийн нийлбэр тоо нь 80.</p> <p>Уншигч дармал эхээс 40, бичмэл эхээс 35 үг, нийлбэр нь 75 үг уншсан бол $75 \times 100 : 80 = 93.7\%$</p> <p>100% уншсан бол 5 оноо 10% буурах тутамд 0.1 оноо хасаж үнэлнэ.</p> <p>Байгууллагаас гүйцэтгэлийн хувь нь хамгийн өндөр үзүүлэлтэй 5 хүн сумын тэмцээнд оролцож I байр эзэлсэн бол 2 оноо, II байр эзэлсэн бол 1.5 оноо, III байр эзэлсэн бол 1 оноо</p> <p>Сумаас шалгарсан 5 хүн аймгийн тэмцээнд оролцож I байр эзэлсэн бол 3 оноо II байр эзэлсэн бол 2.5 оноо III байр эзэлсэн бол 2 оноо</p>	
12.	<p>“Сайхан бичигтэн” уралдаан зохион байгуулах /10 оноо/ Байгууллага хамт олноо “Сайхан бичигтэн” уралдаанд оролцуулах /5 оноо/ Байгууллагаас шалгарсан хүнийг сумын тэмцээнд бэлтгэн оролцуулах /2 оноо/ Сумаас шалгарсан хүнийг аймгийн тэмцээнд бэлтгэн оролцуулах /3 оноо/</p>	<p>“Сайхан бичигтэн” уралдаанд байгууллага хамт олноо 100% оролцуулсан бол 5 оноо 10 хувь буурах тутам 0.5 оноо хасна.</p> <p>Сумандаа “Сайхан бичигтэн” уралдаанд: I байр эзэлсэн бол 2 оноо II байр эзэлсэн бол 1.5 оноо III байр эзэлсэн бол 1 оноо</p> <p>“Сайхан бичигтэн” аймгийн уралдаанд: I байр эзэлсэн бол 3 оноо II байр эзэлсэн бол 2.5 оноо III байр эзэлсэн бол 2 оноо IV байр эзэлсэн бол 1 оноо V байр эзэлсэн бол 0.5 оноо</p>	
13.	<p>“Үндэсний бичиг заах арга зүй, урлан бүтээх” уралдаан зохион байгуулах</p>	<p>Удирдамжид заасан тавигдах шаардлагын дагуу үнэлнэ.</p>	
14.	<p>Монгол бичгийн албан бус сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих /1.5 оноо/</p>	<p>Дэмжлэг үзүүлж урамшуулал олгосон бол 1.5 оноо</p>	
15.	<p>“Хүмүүн бичиг” сониныг захиалах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлж, сурталчлах /10 оноо/</p> <p>“Хүмүүн бичиг” сонины захиалан хэрэглэх /5 оноо/ Орон нутгийн телевиз, хэвлэл мэдээлэл, цахимаар сурталчлах /5 оноо/</p>	<p>Байгууллагын хамт олон 100 хувь “Хүмүүн бичиг” сонин захиалан сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж буй бол 5 оноо, 90% бол 4 оноо, 80% бол 3 оноо, 70% бол 2 оноо, 60% бол 1 оноо өгнө.</p> <p>Хэвлэл мэдээлэл, телевиз, цахимаар үндэсний өв, бичиг, соёлыг улиралд 3, жилд 12 удаа сурталчилсан бол 5 оноо, улиралд 2, жилд 8 удаа бол 4 оноо, улиралд 1, жилд 4 удаа бол 3 оноо, жилдээ 3 удаа бол 2 оноо, жилдээ 2 удаа бол 1 оноо өгч дүгнэнэ.</p>	
16	<p>Үндэсний бичиг, биет бус өв, соёл, түүхийн дурсгалыг судлан сурталчлах</p>	<p>“Үндэсний бичиг-Бидний бахархал” уралдаан гэрийн даалгаварт тавих шалгуураар үнэлнэ.</p>	
Нийт 100 оноо			

**АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ ХУВААРЬ**

Д/д	Хариуцсан ажилтан	Сум	Байгууллага	Албан тушаал	Холбоо барих утас
1.	Б.Оюунбилэг Т.Эрдэнэсайхан	Орхон, Бүрэгхангай	ОБГ, ЦГ, ШШГА, ШША, Тагнуулын хэлтэс,	АЗТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн ЭӨЦС-ийн багш	99794909 99507847
2.	М.Батжаргал Д.Гүнсмаа	Могод, Хишиг-Өндөр	ТХ, ОНӨГ, УБХ, БСУГ	АИТХ-ын мэргэжилтэн ЭӨЦС-ийн багш	99349444 99473795
3.	Ч.Баттуяа С.Биндэрьяа	Бугат, Сэлэнгэ	Булган сумын сургуулиуд	Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн НБД Ахмад багш	99006326 96096326 99894381
4.	Л.Намуунтуяа М.Энэрхмаа	Хутаг-Өндөр, Тэшиг	ХХААГ, СХЗХ, ГХБХБГ,	БСУГ-ын мэргэжилтэн Ахмад багш	99963432 95972062
5.	Т.Дэлгэрмаа О.Уранчимэг	Баян-Агт, Сайхан,	ЭМГ, АНЭ, Өрхийн эмнэлэг, НДХ	НТБТ-ын захирал Ахмад багш	95793595 95767766
6.	Г.Баярчимэг О.Оюун	Хангал, Хялганат	МХГ, ХХҮГ, БТСГ, СХАА,	Булган сумын 1 дүгээр сургуулийн багш Зөвлөх багш	99553907 99209894
7.	Ч.Отгонбаяр Х.Очир-Эрдэнэ	Рашаант, Гурванбулаг	БОАЖГ, СХ, ХХҮГ, Мал эмнэлэг	ЭӨЦС-ийн багш	99235398 88588561
8.	Д.Баярсайхан П.Рина	Баяннуур, Дашинчилэн,	ХГБЗХГ, Аймгийн Музей, Булган сумын цэцэрлэгүүд	Аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга Ахмад багш	94952828 99756559
9.	Г.Наранцэцэг П.Баянжаргал	Булган сум	АЗДТГ, АИТХ, ХЖТ	Ахмад багш Ахмад багш	99298651 99298410
10.	Б.Бямбасүрэн Б.Лхамсүрэн	Аудит, Аймгийн прокурор, Аймгийн Шүүх,		Спортын дунд сургуулийн багш ЭӨЦС-ийн багш	89262409 99299864
11.	Г.Сарантуяа Д.Уламбаяр	УЦУОША, АТНС, МСҮТ, ХААН МСҮТ, Соёлын ордон		НТБТ-ийн багш ЭӨЦС-ийн багш	99184385 99984679
12.	Г.Ганзул С.Тунгалаг	Булган Мээж, Булган АЗЗА, ЭБЦТС, Улсын нөөцийн газар, Аймгийн нөөц, Мэдээлэл, холбоо сүлжээ, Холбооны газар, Шуудан үйлчилгээ, Авто тээврийн Булган аймаг дахь салбар,		Булган сумын 3 дугаар сургуулийн багш Ахмад багш	95642225 99898092
13.	Н.Солонго Ц.Мөнгөнтуяа	Газар хөдлөлтийг бүртгэх алба, Хорих 439 дүгээр анги, Булган сум дахь сум дундын ойн анги		ЭӨЦС-ын багш Булган сумын 1-дүгээр сургууль	99204459 89016019
14.	Б.Отгонсүвд	Банкууд		АЗДТГ-НБХ	99604657

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын 12-ны өдрийн тоот захирамжийн гуравдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ БИЧГИЙН “ШИЛДЭГ СУРГАГЧ БАГШИЙН БАГ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

2021.01.12

Булган сум

Зорилго: 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагч, иргэдэд үндэсний бичгийн сургалт зохион байгуулж, тэднээс “Сургагч багш”-ийг бэлтгэхэд оршино.

Зорилт:

- Сургагч багш нарын баг бүрдүүлэх;
- Анхан болон дунд шатны сургалтуудыг зохион байгуулах;
- Сургагч багш нарыг бэлтгэж, хичээл заах арга зүйд сургах;
- Сургагч багш нарын тоог нэмэгдүүлж, багаар ажиллах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

Хамрах хүрээ: Төрийн албан хаагчид, ЕБС-ийн багш, иргэд

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 12-аас 2021 оны 12 дугаар сарын 10 хүртэл

Уралдааны шалгуур үзүүлэлт буюу дүгнэх журам:

№	Үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
1.	Баг бүрдүүлэх /1-5 оноо/ 5 багштай сургагч багшийн багийг үүсгэн байгуулж ажилласан байх	5 хүнтэй баг-5 оноо 5 хүн хүрээгүй тохиолдолд хүн тутмаас 1 оноо хасна.	
2.	Сургалт зохион байгуулах Үндэсний бичгийн сургалтыг 10 сарын турш зохион байгуулж, 80-аас доошгүй хүнд анхан болон дунд шатны мэдлэг, чадварыг олгосон байх /1-10 оноо/	80 хүн сургасан бол -10 оноо Дутуу хүн тутамд 0.1 оноо хасна.	
3.	Сургалтын амжилт: /1-10 оноо/ Суралцагчдыг 100 хувь сургасан байх	Хугацаандаа 100 хувийн амжилттай сургасан бол 10 оноо Амжилт нь 60 хувьд хүрээгүй суралцагч тус бүрээс 1 оноо хасаж дүгнэнэ.	
4.	Сургагч багш бэлтгэх: Суралцагчдын дундаас сайн сурсан 1 хүнийг сургагч багшаар бэлтгэн “Батламж” өгч үйл ажиллагаанд оруулах /1-8 оноо/	8 сургагч багш бэлтгэхэд - 8 оноо Бэлтгэсэн сургагч багшийн тоогоор 1 оноо өгч дүгнэнэ.	
5.	Үндэсний хэл бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх аянд оролцох:	Уншуулж бичүүлж сургасан хүн бүрт 1 оноо өгнө.	

6.	Баримт бүрдүүлэн дүгнэлт бичих Сургалтын үйл явцын баримтыг бүрдүүлэх, “Өөрийн үнэлгээ” хийж, дүгнэлт бичин сумын ЗДТГ-ын ажлын хэсэгт, 2-р шатанд шалгарсан багийн материалыг албан тоотын хамт заасан хугацаанд нь АЗДТГ-ын ажлын хэсэгт тус тус хүргүүлнэ. /1-3 оноо/	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийг гарын үсэг, тамга тэмдэг, фото зураг зэргээр баримтжуулан нэг хавтсанд хийнэ. Хавтасны нүүрэнд хаяг, утасны дугаар бичнэ. Хавтасны эхний нүүрэнд өөрийн товч танилцуулгыг анкетийн хэлбэрээр бичиж мэргэжлийн зурагчнаар авахуулсан 6x9 хэмжээтэй зургийг наасан байна.	
Нийт оноо-46			

Дүгнэх журам:

Тайлан мэдээг улирал бүрийн 3, 6, 9, 10 дугаар сарын 10-ны дотор тухайн сумын ажлын хэсгээр дамжуулан албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

Тайлан мэдээ болон болон хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгалтын дүнд үндэслэн аймгийн ажлын хэсэг үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш нарын багш”-ийг шалгаруулна.

Шагнал урамшуулал:

1-р байр: Өргөмжлөл, 2 000 000 төгрөг

2-р байр: Өргөмжлөл, 1 000 000 төгрөг

3-р байр: Өргөмжлөл, 500 000 төгрөг

ҮНДЭСНИЙ БИЧГИЙН “ШИЛДЭГ СУРГАГЧ БАГШ” ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ

2021.01.12

Булган аймаг

Зорилго: 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшил, иргэд, суралцагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх, масс сургалтад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Аймаг, сум, ахмад болон монгол хэл, уран зохиолын багш, сайн дурын сургагч багш

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2021 оны 12 сарын 10

Үйл ажиллагааны чиглэл:

- Өөрийн амьдарч буй аймаг, сум, баг болон ажилладаг байгууллагын албан хаагч, иргэд, суралцагчдад үндэсний бичиг заах /Ахмад багш болон сайн дурын иргэнтэй хамтарч ажиллаж болно./
- Аймаг, сум, багт үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлах
- Аймаг, сум, багт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хаягийг үндэсний бичгээр хаягжуулах, ажлыг зохион байгуулах
- Масс сургалтыг бүх шатанд сайжруулах

Шалгуур үзүүлэлт:

№	Үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
1	Унших, бичих чадвараар гарааны судалгаа авч, ахицыг тооцож ажилласан байдал /10 оноо/	-Гарааны судалгааг хүн бүрээр гаргасан бол 5 оноо -Ахицыг тооцсон бол 5 оноо	
2	Үндэсний бичгийн мэдлэг чадварын түвшинг дээшлүүлэн, ахиц гаргасан байдал /10 оноо/	Сурагч болон иргэдийн үндэсний бичгийн мэдлэг чадварын түвшин гарааны үнэлгээг 50% ахиулсан бол 10 оноо 40%- 8 оноо 30%- 6 оноо 20%- 4 оноо 10%- 2 оноо	
3	Анхан, дунд, гүнзгий шатны хөтөлбөр боловсруулж, явцын үнэлгээ хийсэн байдал /10 оноо /	-Анхан, дунд, гүнзгий шатны хөтөлбөр боловсруулсан бол- 5 оноо -Явцын үнэлгээг хийсэн бол- 5 оноо	
4	Үр дүнд хүрсэн байдал ба хамрагдсан хүний тоо мэдээг баримттай хавсаргасан байдал /20 оноо/	-Анхан шатны сурагч болон иргэд гараанаас унших чадварыг 60 хувьд, бичих чадварыг 30 хувьд хүргэсэн бол 10 оноо -Дунд шатны сурагч болон иргэд гарааны үнэлгээнээс унших чадварыг 60 хувьд, бичих чадварыг 40 хувьд хүргэсэн бол 10 оноо -Хамруулсан хүний тоогоор дараах байдлаар үнэлж дүгнэнэ. Нэг хүний хамрагдсан тоог 0.3 оноо гоор тооцно.	

Дүгнэх журам:

Тайлан мэдээг улирал бүрийн 3, 6, 9, 10 дугаар сарын 10-ны дотор тухайн сумын ажлын хэсгээр дамжуулан албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

Тайлан мэдээ болон болон хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгалтын дүнд үндэслэн аймгийн ажлын хэсэг үндэсний бичгийн “Шилдэг сургагч багш”-ийг шалгаруулна.

Шагнал урамшуулал:

1-р байр: Өргөмжлөл, 1 000 000 төгрөг

2-р байр: Өргөмжлөл, 700 000 төгрөг

3-р байр: Өргөмжлөл, 500 000 төгрөг

**ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН “ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”
ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ /Анхан шат/**

2021.01.12

Булган аймаг

Зорилго: 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшил, иргэд, суралцагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх, албан бичиг баримтыг үндэсний бичгээр хөтлөх, мэдлэг, чадварт сургахад оршино.

Зорилт:

- Үндэсний бичгийн “Анхан шат”-ны сургалтад суралцаж, уншиж, бичиж сурах
- Байгууллагын дотоод албан бичгийг кирилл, үндэсний бичгээр хослуулан бичих хэрэглээг бий болгох

Хамрах хүрээ: Аймгийн хэмжээний бүх төрийн албан хаагчид

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 12 оос 2021 оны 12 дугаар сарын 10

Уралдааны шалгуур үзүүлэлт буюу дүгнэх журам:

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
1.	Сургалтад суралцах /1-10 оноо/ Үндэсний бичгээр анхан шатны сургалтад суралцаж бичиж, уншиж сурах	Анхан шатны суралцагч жилийн эцэст минутад 50 үг уншиж, 30 үгийг зөв бичвэл 10 оноо Дутуу уншсан, бичсэн үг бүрээс 0.1 оноо хасаж тооцно.	
2.	Идэвх оролцоо /1-10 оноо/ Хичээлийн ирц, даалгаврын биелэлт 100 хувь байх	Хичээлийн ирц 100 хувь бол 5 оноо , даалгаврын биелэлт 100 хувь бол 5 оноо Ирц тасарсан, даалгаврыг огт хийгээгүй тохиолдолд тус бүр 1 оноо хасна. Дутуу хийсэн бол 0.5 оноо хасна.	
3.	Бие даан өөрийгөө хөгжүүлсэн байх: /30 оноо/ Үндэсний бичгээр эхүүдийг уншсан байх Хуулан бичлэг хийсэн байх Үндэсний бичгээс галиглан бичих Кириллээс үндэсний бичигт хөрвүүлэх	120-оос дээш үгтэй 60 эх буюу сэдвийг уншиж хуулан, галиглаас үндэсний бичигт хөрвүүлнэ. /Төрөл тус бүр 10 оноотой/ Нэг эх дутуу байвал 1 оноо хасагдана.	
4.	Үндэсний бичгийн цахим бичвэрийн чадвараа хөгжүүлэх: /10 оноо/ -Албан тоот бичих -Өргөмжлөлийн үг, өгүүлбэрийг бичиж сурах -Хэлтэс, агентлагуудын хаягийг зөв бичиж сурах -Ажлын баримт бичгүүдийг үндэсний,	5 шалгуур үзүүлэлтийг бүрэн хийсэн тохиолдолд 10 оноо Дутуу үзүүлэлт бүрээс 2 оноо хасна.	

	кирилл бичгээр хаягжуулах -Байгууллагын хамт олны овог нэрийг үндэсний бичгээр бичиж сурах /10 оноо/		
5.	Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх аянд оролцох: /0-5 оноо/ 5 хүнд үндэсний бичиг сурахад нь тусалсан байх	Уншуулж, бичүүлж сургасан хүн бүрт 1 оноо өгнө.	
6.	Баримт материал бүрдүүлэн дүгнэлт бичих: /1-3 оноо/ Сургалтын үйл явцын баримтыг бүрдүүлэх, “Өөрийн үнэлгээ” хийж, дүгнэлт бичин сумын ЗДТГ-ын ажлын хэсэгт, 2-р шатанд шалгарсан багийн материалыг албан тоотын хамт заасан хугацаанд нь аймгийн ажлын хэсэгт тус тус хүргүүлнэ. Дээрх 5 үзүүлэлт тус бүрт үр дүнгийн дүгнэлт бичих	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийг гарын үсэг, тамга тэмдэг, фото зураг зэргээр баримтжуулан нэг хавтсанд хийнэ. Хавтасны нүүрэнд хаяг, утасны дугаар бичнэ. Хавтасны эхний нүүрэнд өөрийн товч танилцуулгыг анкетийн хэлбэрээр бичиж мэргэжлийн зурагчнаар авахуулсан 6х9 хэмжээтэй зургийг наасан байна. Үзүүлэлт бүрийн үр дүнг баримтад тулгуурлан зөв тооцож бичсэн бол 0,5 оноо өгнө. Баримтаар батлагдаагүй тохиолдолд 0,5 оноог үзүүлэлт бүрээс хасаж үнэлнэ. Үр дүнг баримтад тулгуурлан зөв тооцож бичсэн бол 3 оноо	
	Нийт оноо-88		

Дүгнэх журам:

Тайлан мэдээг улирал бүрийн 3, 6, 9, 10 дугаар сарын 10-ны дотор тухайн сумын ажлын хэсгээр дамжуулан албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

Тайлан мэдээ болон болон хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгалтын дүнд үндэслэн аймгийн ажлын хэсэг үндэсний бичгийн “Шилдэг төрийн албан хаагч”-ийг шалгаруулна.

Шагнал урамшуулал:

1-р байр: Өргөмжлөл, 1 000 000 төгрөг

2-р байр: Өргөмжлөл, 700 000 төгрөг

3-р байр: Өргөмжлөл, 500 000 төгрөг

**ҮНДЭСТНИЙ БИЧИГТЭН “ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”
ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ /Дунд шат/**

2021.01.12

Булган аймаг

Зорилго: 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшил, иргэд, суралцагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх, албан бичиг баримтыг үндэсний бичгээр хөтлөх, мэдлэг, чадварт сургахад оршино.

Зорилт:

Үндэсний бичгийн “Дунд шат”-ны сургалтад суралцан, уншиж, бичиж чадвараа ахиулах;

Байгууллагын дотоод албан бичгийг кирилл, үндэсний бичгээр хослуулан бичиж сурах хэрэглээг бий болгох;

Цахим орчинд үндэсний бичгээр аливаа бичиг баримтыг боловсруулж ажлын хэрэглээ болгох;

Хамрах хүрээ: Аймгийн хэмжээний бүх төрийн албан хаагчид

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 12-оос 2021 оны 12 дугаар сарын 10

Уралдааны шалгуур үзүүлэлт буюу дүгнэх журам:

№	Үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
1	Сургалтад суралцах: /1-10 оноо/ Үндэсний бичгийн “Дунд шатны сургалт”-д суралцаж шударга хурдан уншиж, алдаагүй бичих чадварт сурах Суралцагчийн Үндэсний бичгийн чадварын түвшинг үнэлэх	“Минутын уншлага”, “Цээж бичиг”-ээр гарааны болон ахицын судалгаа авна. Дунд шатны суралцагч жилийн эцэст минутад 150-аас дээш үг уншиж, 60 үгийг зөв бичвэл 10 оноо Дутуу уншсан, бичсэн үг болгоноос 0.1 оноо хасна.	
2	Идэвх оролцоо: /10 оноо/ Хичээлийн ирц, даалгаврын биелэлт 100 хувь байх	Хичээлийн ирц 100% бол 5 оноо Даалгаврын биелэлт 100 хувь бол 5 оноо Ирц тасарсан, даалгаврыг огт хийгээгүй тохиолдолд тус бүр 1 оноо хасна. Дутуу хийсэн бол 0.5 оноо хасна.	
3	Бие даан өөрийгөө хөгжүүлэх /30 оноо/ Үндэсний бичгээр эхүүдийг уншсан байх Хуулан бичлэг хийсэн байх Үндэсний бичгээс галиглан бичих кириллээс үндэсний бичигт хөрвүүлэх Үндэсний бичгийн зөв бичих дүрмийг судалж сурах	200-аас дээш үгтэй 80 эх буюу сэдвийг уншиж хуулах, галиглах, хөрвүүлэх ажлуудыг хийх /Төрөл тус бүр 10 оноотой/ Нэг эх дутуу байвал 1 оноо хасагдаж тооцно.	

4	<p>Үндэсний бичгийн цахим бичвэрийн чадвараа хөгжүүлэх:/30 оноо/ Цахим орчинд үндэсний бичгээр бичвэр боловсруулж сурах /10 оноо/</p> <p>Цахим орчинд байгууллагын дотоод албан бичгийг хөтөлж хэвших /10 оноо/</p> <p>Ажлын баримт бичгүүдийг үндэсний бичгээр хаягжуулах /5 оноо/</p>	<p>Бичвэрийг 100 хувь боловсруулж сурсан бол 10 оноо</p> <p>10 хувиар буурах тутамд 1 оноо хасна.</p> <p>Ажлын байрны тодорхойлтын дагуу боловсруулдаг бичиг баримтын төрөл тус бүрд 2 оноо</p> <p>Жиш: 5 төрлийн бичиг баримтыг үндэсний бичгээр бичиж сурсан бол 10 оноо</p> <p>100 хувь хаягжуулсан бол 5 оноо</p> <p>Дутуу хийгдсэн тохиолдолд 1 оноо хасна.</p>	
5	<p>Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх аянд оролцох 10 хүнд үндэсний бичиг сурахад нь тусалсан байх /0-10 оноо/</p>	<p>Уншуулж бичүүлж сургасан хүн бүрт 1 оноо өгнө.</p>	
6	<p>Баримт материал бүрдүүлэн дүгнэлт бичих: /1-3 оноо/ Сургалтын үйл явцын баримтыг бүрдүүлэх, “Өөрийн үнэлгээ” хийж, дүгнэлт бичин сумын ажлын хэсэгт, 2-р шатанд шалгарсан багийн материалыг албан тоотын хамт заасан хугацаанд нь аймгийн ажлын хэсэгт тус тус хүргүүлнэ. Дээрх 5 үзүүлэлт тус бүрт үр дүнгийн дүгнэлт бичих</p>	<p>Үзүүлэлт тус бүрийн биелэлтийг гарын үсэг, тамга тэмдэг, фото зураг зэргээр баримтжуулан нэг хавтсанд хийнэ. Хавтасны нүүрэнд хаяг, утасны дугаар бичнэ. Хавтасны эхний нүүрэнд өөрийн товч танилцуулгыг анкетийн хэлбэрээр бичиж мэргэжлийн зурагчнаар авахуулсан 6х9 хэмжээтэй зургийг наасан байна. Үзүүлэлт бүрийн үр дүнг баримтад тулгуурлан зөв тооцож бичсэн бол 0,5 оноо өгнө. Баримтаар батлагдаагүй тохиолдолд 0,5 оноог үзүүлэлт бүрээс хасаж үнэлнэ.</p>	
7	<p>Нийт оноо-88</p>		

Дүгнэх журам:

Тайлан мэдээг улирал бүрийн 3, 6, 9, 10 дугаар сарын 10-ны дотор тухайн сумын ажлын хэсгээр дамжуулан албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

Тайлан мэдээ болон болон хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгалтын дүнд үндэслэн аймгийн ажлын хэсэг үндэсний бичгийн “Шилдэг төрийн албан хаагч”-ийг шалгаруулна.

Шагнал урамшуулал:

1-р байр: Өргөмжлөл, 1 000 000 төгрөг

2-р байр: Өргөмжлөл, 700 000 төгрөг

3-р байр: Өргөмжлөл, 500 000 төгрөг

“ШИЛДЭГ СУРГАГЧ БАГШИЙН БАГ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ

2021.01.12

Булган аймаг

Уралдаанд оролцох багийн хамт олон, түүнийг дүгнэх ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд зориулав.

Ерөнхий мэдээлэл:

Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнийн санаачилгаар 2021 оныг “Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх” жил болгох шийдвэр гарсантай холбогдуулан монгол бичгийг сургахад идэвх санаачилгатай оролцсон “Багш нарын баг”-ийг хөхиүлэн дэмжих зорилгоор “Шилдэг сургагч багшийн баг” уралдааны болзол, шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг хүргүүлж байна.

Уралдааныг зохион байгуулах талаар:

Үндэсний бичгийн сургалтыг 8 сарын турш зохион байгуулж, 80-аас доошгүй хүнд анхан болон дунд шатны мэдлэг, чадварыг олгосон байна. Сургагч багшийн баг нь таван хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэг удаагийн сургалтаар 10 хүнд хичээл заана. Халдвар хамгааллын дэглэмийг барьж хичээллүүлнэ. Суралцагчдын дундаас сайн сурсан 1 хүнийг “Сургагч багш”-аар бэлтгэн “Батламж” өгч үйл ажиллагаанд оруулах буюу уралдааны хугацаанд нэг сургагч багш 8 хүнийг, багаараа 40 хүнийг “Сургагч багш”-аар бэлдсэнээр “Сургагч багш”-ийн тоог нэмнэ.

Анхан шатны сургагч багшийн “Батламж” авсан 1 хүн 5 хүнд, дунд шатных нь 10 хүнд үндэсний бичгийн сургалтыг зохион байгуулж уралдааны хугацаанд нийт 120 хүнийг уншуулж, бичүүлж сургасан байх юм.

“Сургагч багш” нарын баг багш бэлтгэх ажилдаа идэвх санаачилгатай оролцож жилдээ 600 хүнийг сургасан тохиолдолд аймгийн “Шилдэг сургагч багш” уралдаанд оролцох боломжтой.

Уралдааныг үнэлэх талаар:

“Өөрийн үнэлгээний арга”-аар үнэлгээг хийнэ. Үнэлгээ 3 үе шаттай.

1-р үе шат. “Шилдэг сургагч багшийн баг” болзолд заасан үнэлгээний үзүүлэлт, шалгуур, дүгнэлт гэсэн хүснэгтээр өөрийн багийн сургалтын үйл явц, үр дүнг баримт нотолгоонд тулгуурлан үнэлж, оноо өгч дүгнэлт бичнэ. Материалаа хавтасжуулж орон нутгийн ажлын хэсэгт хугацаанд нь хүлээлгэн өгнө. Болзол, зөвлөмжтэй сайтар танилцаж үнэлгээгээ зөв, оновчтой хийхийг анхаарай.

2-р шат. Орон нутгийн ажлын хэсэг багуудын материалыг үзүүлэлт тус бүрээр нь хянан үзэж баримтаар нотлогдож байгаа эсэхийг шалгаж журамд заасны дагуу оноог хасах, нэмэх эрхийг эдэлнэ. Шалгарсан “Шилдэг сургагч багшийн баг”-ийн материалыг аймгийн ажлын хэсэгт албан тоотын хамт хугацаанд нь ирүүлнэ. Үнэлгээ хийхдээ дүгнэлт хэсэг дээр үр дүнгээ зөв тооцсон эсэх, тэр нь баримтаар нотлогдож байгааг хянан шударга зөв үнэлэхийг анхааруулъя.

Удирдамжийн 3 дахь үзүүлэлт буюу сургагч багш нарын сургалтын үр дүнг үнэлэхдээ 1-р шатанд сургагч багш өөрөө, 2, 3-р шатанд тухайн ажлын хэсэг “Минутын уншлага”, “Цээж бичиг”-ээр шалгалт авч баталгаажуулна. “Батламж” авсан “Сургагч багш”-ийн заасан хичээлийн үр дүнг суралцагчдаас нь галиглах, хөрвүүлэх, уншуулах 3 хэлбэрээр шалгаж баталгаажуулаарай.

“Шилдэг сургагч багшийн баг”, “Сургагч багш” нарын сургалтын үр дүнг сэтгэгдэл, талархал, захидал зэргээр үнэлж болох юм.

Тухайн орон нутгийн ажлын хэсэг “Шилдэг сургагч багш нарын баг”-ийн сургалтын үйл явцтай улиралд 1 удаа танилцаж, зөвлөмж өгч үйл ажиллагааг нь сурталчилж ажиллахыг хүсье.

ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН “ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ

2021.01.12

Булган аймаг

Уралдаанд оролцох төрийн албан хаагч, ажилтан ажилчид уралдааныг дүгнэх ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд зориулав.

Ерөнхий мэдээлэл:

Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнийн санаачилгаар 2021 оныг “**Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх**” жил болгох шийдвэр гарсантай холбогдуулан “Хос бичигтэн” болох бэлтгэл ажлыг идэвхжүүлэх үйл ажиллагаанд санаачилгатай манлайлан оролцсон Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч” шалгаруулах уралдааны болзол, шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг хүргүүлж байна. Одоогийн байдлаар манай аймагт 4000 гаруй төрийн албан хаагчид ажиллаж иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.

МУЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын18-ны өдрийн 96 тогтоолоор “**Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3**”-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд түүний 3.3.7 дахь заалтад төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх, Монгол хэлний тухай хуулийн 24-ийн 7.2 дахь хэсэгт 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах тухай заажээ. Иймд төрийн албан хаагч бид “Хос бичигтэн” болох монгол бичигт суралцах, мэдлэг, чадвараа ахиулах хэрэгцээ шаардлага тулгарч буй тул үндэсний бичиг сурах үйл ажиллагаа бидний чухал зорилт болж байна.

Уралдааныг зохион байгуулах талаар:

Дээрх зорилтыг хангахын тулд төрийн албан хаагчид үндэсний бичгийн анхан болон дунд шатны сургалтад суралцаж монгол бичгээр унших, бичих чадвараа сайжруулах “**Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх**” жилд идэвхтэй оролцож “**Хос бичигтэн**” болох бэлтгэл ажлыг эхлүүлж байгаа болно.

Уралдаанд төрийн албан хаагч, ажилтан, ажилчид оролцоно.

Үндэсний бичгийн чадвараа үнэлж анхан ба дунд шатны сургалтад суралцана.

Үндэсний бичгийн анхан шатны сургалтад уншиж бичдэггүй албан хаагчид суралцаж цагаан толгойд тайлагдана. Тийм учраас анхан болон дунд шатны гэсэн 2 уралдааны болзол хүргүүлж байна.

Дунд шатанд үндэсний бичгийн зохих мэдлэгтэй албан хаагчид суралцаж чадварын түвшнээ дээшлүүлнэ.

Анхан болон дунд шатны сургалтад идэвхтэй сайн суралцсан тус бүр 1 хүн “Сургагч багш”-ийн батламж авч 5-10 хүнд үндэсний бичгийн анхан шатны сургалтыг зохион байгуулж бусдад

тусална. Үндэсний бичгээ сайн сурсан албан хаагчийг хөхиүлэн дэмжиж “Шилдэг үндэсний бичигтэн төрийн албан хаагч” уралдааны болзлын дагуу шагнаж урамшуулна.

Уралдааныг үнэлэх талаар:

Уралдааныг “Өөрийн үнэлгээний арга”-аар үнэлгээг хийнэ. Үнэлгээ 3 үе шаттай.

1-р үе шат. Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч” уралдааны болзолд заасан үнэлгээний үзүүлэлт, шалгуур, дүгнэлт гэсэн хүснэгтээр өөрийн сурах, сургах үйл ажиллагааны явц, үр дүнг баримт нотолгоонд тулгуурлан үнэлж, оноо өгч дүгнэлт бичнэ. Материалаа хавтасжуулж орон нутгийн ажлын хэсэгт заасан хугацаанд нь хүлээлгэн өгнө. Болзол, зөвлөмжтэй сайтар танилцаж үнэлгээгээ зөв, оновчтой хийгээрэй.

2-р шат. Орон нутгийн ажлын хэсэг Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч”-ийн материалыг үзүүлэлт тус бүрээр нь хянан үзэж баримтаар нотлогдож байгаа эсэхийг шалгаж журамд заасны дагуу оноог хасах, нэмэх эрхийг эдэлнэ. Шалгарсан Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч”-ийн материалыг аймгийн ажлын хэсэгт албан тоотын хамт хугацаанд нь ирүүлнэ. Үнэлгээ хийхдээ дүгнэлт хэсэг дээр үр дүнгээ зөв тооцсон эсэх тэр нь баримтаар нотлогдож байгааг хянан шударга зөв үнэлэхийг анхааруулъя.

Удирдамжийн 1 дэх үзүүлэлт буюу сургалтад суралцсан амжилтын үр дүн, явцын үнэлгээг баталгаажуулахын тулд “Минутын уншлага”, “Цээж бичиг”-ээр шалгалт авна. Дунд шатны суралцагчийн гарааны судалгааг ахицын судалгаатай харьцуулж оноо өгөхийг анхаарна уу.

Хоёр дахь үзүүлэлт болох хичээлийн ирц, даалгаврын биелэлтийг сургагч багшийн гарын үсгээр баталгаажуулан дүгнэсэн эсэхийг хянаж шалгаарай.

Гурав дахь үзүүлэлтэд анхан шатны суралцагч 120-оос дээш үгтэй 60 эх, дунд шатных 200-аас дээш үгтэй 80 эх буюу сэдвийг уншиж хуулах, галиглах, хөрвүүлэх ажлыг хийсэн байх тул тэдний дэвтрийг үзэж сэдвүүдийг тоолон баталгаажуулж оноог нягтлаарай.

Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч”-ийг үнэлэхдээ өөртөө үндэсний бичгийн орчин бүрдүүлсэн байдал, дотоод албан хэргийн хөтлөлтөдөө үндэсний бичгийн хэрэглээ болгосон эсэх зэргийг ажлын байранд нь шалгаж 4-р үзүүлэлт батлагдаж буйг дүгнээрэй.

Шалгаруулалтын эцсийн үнэлгээг гаргахдаа тухайн албан хаагч хэр идэвх санаачилгатай бүтээлч суралцаж байгааг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Тухайн орон нутгийн ажлын хэсэг Үндэсний бичигтэн “Төрийн албан хаагч”-ийн сургалтын үйл явцтай улиралд 1 удаа танилцаж, зөвлөмж өгч үйл ажиллагааг нь сурталчилж ажиллахыг хүсье.

**“ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН ИРГЭН”
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2021.01.12

Булган аймаг

Зорилго: Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх жилийн ажлын үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний бичгээр бичих, унших чадварт суралцуулж түүний хэрэглээг бий болгоход оршино.

Зорилт:

- Үндэсний бичгийн “Анхан, дунд шат”-ны сургалтад суралцаж, уншиж, бичиж сурах
- Өөрийн хэрэгцээнд монгол бичгийг ашиглан бичвэр бичиж сурах
- Бусдад үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэхэд оролцох

Хамрах хүрээ: Аймаг, сумдын иргэд, насанд хүрэгчид

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 15-наас 2021 оны 12 дугаар сарын 05 хүртэл

Уралдааны шалгуур үзүүлэлт буюу дүгнэх журам:

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
1	Сургалтад суралцсан амжилтыг үнэлэх /5 оноо/	<p>Уралдаанд оролцсон иргэн Анхан болон дунд шатны сургалтад суралцсан иргэний мэдлэг, чадварын түвшинг сургагч багш үнэлнэ. Иргэн үндэсний бичигт суралцсан чадвараа “Маш сайн”, “Сайн”, “Дундаж” түвшинд сурсан гэж өөрөө үнэлж, сургагч багш шалгалтаар баталгаажуулна. Маш сайн түвшинд сурсан бол 5 оноо Сайн түвшинд сурсан бол 4 оноо Дундаж түвшинд сурсан бол 3 оноо гэж үнэлнэ. “Маш сайн” гэж үнэлэгдсэн иргэн уралдаанд оролцох хүсэлт, материалаа багийн Засаг даргад хугацаанд нь өгнө. Багаас шалгарсан иргэний материалын үнэлгээ, дүгнэлтийг онооны дагуу баталгаажуулна. Шалгарсан иргэний материалыг сумын ажлын хэсэгт албан тоотын хамт хүргүүлнэ.</p>	
2	Үндэсний бичигт суралцсан чадварыг үнэлэх Галиглан бичих чадвар /10 оноо/	<p>Бичих чадвар Анхан шатны сургалтад суралцсан иргэн алдаагүй зөв хуулж, галиглан бичсэн бол /10 оноо/ Алдаа тутамд 0.5 оноог хасаж үнэлнэ. Дунд шатны сургалтад суралцсан иргэн монгол бичгээс кириллд хөрвүүлэх; галиг, кириллээс монгол бичигт хөрвүүлсэн бол 10 оноо Алдаа тутамд 0.5 оноог хасаж үнэлнэ</p>	

3	<p align="center">Унших чадвар /10 оноо/ /Шагналт 1 оноо/</p>	<p>Унших чадвар Анхан шатны сургалтад суралцсан иргэн дармал, бичмэл эхээс минутад 40 үг уншиж сурсан бол 10 оноо Үгийн тоо 10-аар буурах тутам 0,5 оноо хасаж үнэлнэ.</p> <p>40-өөс дээш 10 үгээр ахиулж уншвал шагналт 1 оноог нийт онооны нийлбэр дээр нэмэж үнэлнэ.</p> <p>Дунд шатны сургалтад суралцсан иргэн дармал, бичмэл эхээс минутад 80 үг уншиж сурсан бол 10 оноо Үгийн тоо 10-аар буурах тутам 0,5 оноо хасаж үнэлнэ. 80-аас дээш 10 үгээр ахиулж уншвал шагналт 1 оноог нийт онооны нийлбэр дээр нэмэж үнэлнэ.</p>	
4	<p align="center">Хуулан бичих чадвар /10 оноо/</p>	<p>Хуулан бичих чадвар Анхан шатны сургалтад суралцсан иргэн аяны хүрээнд сар бүр 12 хуудастай 1 дэвтэр хуулан бичлэг хийж нийт 8 буюу түүнээс дээш дэвтэр хуулан бичсэн бол 10 оноо Хуулан бичсэн дэвтрийн тоо дутуу бол 0.5 оноо хасаж үнэлнэ.</p> <p>Дунд шатны сургалтад суралцсан иргэн аяны хүрээнд сар бүр 24 хуудастай 1 дэвтэр хуулан бичлэг хийж нийт 10 буюу түүнээс дээш дэвтэр хуулан бичсэн бол 10 оноо Хуулан бичсэн дэвтрийн тоо дутуу бол 0.5 оноо хасаж үнэлнэ.</p>	
5	<p align="center">Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх аянд оролцох /0-25 оноо/</p> <p>Үндэсний бичгээр сурч мэдснээ бусдад зааж сургах ажлыг зохион байгуулах</p>	<p>Анхан шатны суралцагч иргэн 2 хүнийг уншуулж, бичүүлж сургасан бол 5 оноо Хүн тус бүр 2,5 оноо Дунд шатны суралцагч иргэн 4 хүнийг уншуулж, бичүүлж сургасан бол 10 оноо Хүн тус бүр 2,5 оноо Сургасан иргэн нь цаашаа нэг, нэгээр задарч жилийн турш 10 хүнд үндэсний бичиг сургасан бол 10 оноо Хүн тус бүр 2 оноо</p>	
6	<p align="center">Баримт материал бүрдүүлэн дүгнэлт бичих /5 оноо/</p> <p>Сургалтын үйл явцын баримтыг бүрдүүлэх, “Өөрийн үнэлгээ” хийж, дүгнэлт бичнэ. Багийн Засаг дарга, Насан туршийн боловсролын багштай хамтран шалгаруулна. Шалгарсан иргэний материалыг хамт сумын ажлын хэсэгт, сумаас шалгарсныг АЗДТГ-ын ажлын хэсэгт албан тоотын хамт хугацаанд нь тус тус хүргүүлнэ. Дээрх 5 үзүүлэлт тус бүрт үр дүнгийн дүгнэлт бичих</p>	<p>Үзүүлэлт тус бүрийн биелэлтийг гарын үсэг, тамга тэмдэг, фото зураг зэргээр баримтжуулан нэг хавтсанд хийнэ. Хавтасны нүүрэнд хаяг, утасны дугаар бичнэ. Хавтасны эхний нүүрэнд өөрийн товч танилцуулгыг анкетийн хэлбэрээр бичиж мэргэжлийн зурагчнаар авахуулсан 6x9 хэмжээтэй зургийг наасан байна. Үзүүлэлт бүрийн үр дүнг баримтад тулгуурлан зөв тооцож бичсэн бол 1 оноо өгнө. Баримтаар батлагдаагүй тохиолдолд 1 оноог үзүүлэлт бүрээс хасаж үнэлнэ. Үр дүнг баримтад тулгуурлан зөв тооцож бичсэн бол /5 оноо/</p>	
Нийт оноо 66			

Дүгнэх журам:

Тайлан мэдээг улирал бүрийн 3, 6, 9, 10 дугаар сарын 10-ны дотор тухайн сумын ажлын хэсгээр дамжуулан албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

Тайлан мэдээ болон болон хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгалтын дүнд үндэслэн аймгийн ажлын хэсэг үндэсний бичгийн “Үндэсний бичигтэн иргэн”-ийг /анхан, дунд/ шалгаруулна.

Шагнал урамшуулал:

1-р байр: 2, Өргөмжлөл, 1 000 000 төгрөг

2-р байр: 2, Өргөмжлөл, 700 000 төгрөг

3-р байр: 2, Өргөмжлөл, 500 000 төгрөг

АЙМГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

“ШИЛДЭГ ҮНДЭСНИЙ БИЧИГТЭН ИРГЭН” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ

2021.01.12

Булган аймаг

Уралдаанд оролцох иргэд, насанд хүрэгчид, уралдааныг дүгнэх сум, баг, ажлын хэсгийн ахлагч, гишүүд, насан туршийн боловсролын багшид зориулав.

Ерөнхий мэдээлэл:

Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнийн санаачилгаар 2021 оныг “**Үндэсний өв, бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх** аян”-ны жил болгох шийдвэр гарсантай холбогдуулан “Хос бичигтэн” болох бэлтгэл ажлыг идэвхжүүлэх үйл ажиллагаанд санаачилгатай манлайлан оролцсон “Шилдэг үндэсний бичигтэн иргэн” шалгаруулах уралдааны удирдамж, шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг хүргүүлэе. Булган аймагт 61324 иргэн ажиллаж амьдарч байна. Иргэн бүр үндэсний бичигт суралцах шаардлага зүй ёсоор бидний зорилго, зорилт болон гарч ирлээ.

Монгол хэлний тухай хууль, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III" зэрэг эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэхэд иргэн бүр оролцох нийгмийн шаардлага бидний өмнө тулгарч байна. Иймд иргэд, насанд хүрэгчид 2021 оныг “**Үндэсний өв, бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх**” жил болгон зарласан үйл ажиллагаа, аймгаас зарлаж буй “Хос бичигтэн” болох аянд нэгдэж уралдаанд идэвхтэй оролцохыг уриалъя.

Уралдааныг зохион байгуулах талаар:

“**Үндэсний өв, бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх жилийн ажил**”-ын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд иргэд, насанд хүрэгчдийг “Үндэсний бичиг”-ийн анхан болон дунд шатны сургалтад суралцуулж унших, бичих чадвараа дээшлүүлэн “Хос бичигтэн” болоход нь туслахын тулд тус уралдааныг зохион байгуулж байна.

Уралдаанд иргэд, насанд хүрэгчид оролцоно. Үндэсний бичгийг анхан шатны сургалт, бие дааж болон цахимаар сурах хэлбэрээс иргэн өөрөө сонгон суралцаж болно. Гэхдээ “Шилдэг үндэсний бичигтэн иргэн” шалгаруулах уралдаанд анхан болон дунд шатны сургалтад суралцсан иргэн оролцоно. Харин 70-аас дээш насны ахмад иргэнд энэ үзүүлэлт хамаарахгүй болно.

Уралдааны анхан ба дунд шатны суралцагч тус бүрээс “Шилдэг үндэсний бичигтэн иргэн” шалгаруулж урамшуулна.

Баг тус бүрээс “Үндэсний бичиг”-ийн түвшнээр “Маш сайн” гэж үнэлэгдсэн иргэн уралдаанд оролцох хүсэлт, материалаа багийн Засаг даргад хугацаанд нь өгнө. Багаас шалгарсан иргэний материалын үнэлгээ, дүгнэлтийг онооны дагуу баталгаажуулна. Шалгарсан иргэний материалыг сумын ажлын хэсэгт албан тоотын хамт хүргүүлнэ. Сумын ажлын хэсэгт Насан туршийн боловсролын багшийг заавал оролцуулна. Анхан, дунд шатнаас шалгарсан тус бүр нэг, нэг иргэн буюу хоёр хүний материалыг албан тоотын хамт сум, аймгийн ажлын хэсэгт хүргүүлнэ.

Уралдааныг үнэлэх талаар:

Уралдааныг “Өөрийн үнэлгээний арга”-аар үнэлгээг хийнэ. Үнэлгээ 3 үе шаттай. Багийн иргэдийг идэвхтэй оролцуулахын тулд удирдамж, зөвлөмжийг өрх бүрт хүргэхийг хичээж ажиллахыг зөвлөө. Доорх зөвлөмжийн дагуу шалгаруулалтыг үнэлэхдээ удирдамжид заасан үнэлгээний шалгуурыг сайтар уншиж оролцогч иргэний “Өөрийн

үнэлгээ” батлагдаж нотлогдож байгаа эсэхийг хянан үзэж оноог бууруулах, нэмэх эрхийг ажлын хэсэг эдэлнэ. Бууруулах, нэмэх болсон үндэслэлийг дүгнэлт хэсэгт тэмдэглээрэй.

Үндэсний бичгийг бусдад зааж сургасан үйл ажиллагааны оноог баталгаажуулахдаа сургасан хүмүүсээс “Санамсаргүй түүврийн арга”-аар сонгож дармал, бичмэл эхийг уншуулж, галиглан бичүүлж шалгахыг зөвлөж байна.

Хичээл заах явцдаа тухайн суралцагч иргэний ирц, оролцоог бүртгэж, гарын үсгээр баталгаажуулсан, унших, галиглах, хөрвүүлэх төрлөөр суралцагч иргэний хийсэн дэвтэрт үнэлгээ хийж байсан эсэхийг он сар, өдөр, үгэн болон дүрсэн тэмдэглэгээ, оноо хувь, наалт зэргийг сонгон үнэлж “Сургагч багш” гарын үсгээр баталгаажсан болохыг ажлын хэсэг хянаж шалгана. “Сургагч багш”-аар ажиллаж байгаа иргэн суралцагч иргэнийхээ гэрийн даалгавар, галиглан, хуулан, хөрвүүлэн бичсэн дадлага ажлуудыг нь хичээл орох бүрд үнэлж гарын үсэг зурж суралцагч иргэнийг идэвхжүүлж явахыг гол зорилгоо болгон ажилласан байна.

1-р үе шат. “Шилдэг үндэсний бичигтэн иргэн” уралдаанд оролцох иргэн удирдамжид заасан үнэлгээний үзүүлэлт, шалгуур, дүгнэлт гэсэн хүснэгтээр өөрийн сурах, сургах үйл ажиллагааны явц, үр дүнг баримт нотолгоонд тулгуурлан үнэлж, оноо өгч дүгнэлт бичнэ. Удирдамж, зөвлөмжтэй сайтар танилцаж үнэлгээгээ зөв, оновчтой хийхийг анхаарай. Материалаа хавтасжуулж багийн Засаг даргад заасан хугацаанд нь хүлээлгэн өгнө. Багаас шалгарсан иргэний материалын үнэлгээ, дүгнэлтийг онооны дагуу баталгаажуулна. Шалгарсан иргэний материалыг сумын ажлын хэсэгт албан тоотын хамт хүргүүлнэ. Сумын ажлын хэсэгт Насан туршийн боловсролын багшийг заавал оруулна.

2-р шат. Орон нутгийн ажлын хэсэг “Шилдэг үндэсний бичигтэн иргэн”-ий материалыг үзүүлэлт тус бүрээр нь хянан үзэж баримтаар нотлогдож байгаа эсэхийг шалгаж журамд заасны дагуу оноог хасах, нэмэх эрхийг эдэлнэ. Шалгарсан “Шилдэг үндэсний бичигтэн иргэн”-ий материалыг аймгийн ажлын хэсэгт албан тоотын хамт хугацаанд нь ирүүлнэ. Үнэлгээ хийхдээ дүгнэлт хэсэг дээр үр дүнгээ зөв тооцсон эсэх тэр нь баримтаар нотлогдож байгааг хянан шударга зөв үнэлэхийг анхааруулъя.

Тав дахь үзүүлэлтэд анхан шатны суралцагч 12 хуудастай, дунд шатных 24 хуудастай дэвтэрт хуулан бичлэг хийж уралдааны хугацаанд нийт 10 буюу түүнээс дээш дэвтэр хуулан бичлэг хийсэн байх юм. Энэ нь суралцагч иргэн өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг, чадвараа сайжруулах алхам болох тул хичээнгүйлэн хийсэн байхыг зөвлөө. Үндэсний бичгийг олон дахин давтах тутам чадварждаг гэдгийг анхаарна уу! Мөн үндэсний бичгээ илүү сайн сурахыг хүсвэл “Chimee application” гар утсандаа татан суулгаж, зурвас бичин “Булган аймаг Монгол бичиг” нүүр номын бүлэгт илгээж өөрийн монгол бичгийн хэрэглээгээ батжуулж бусадтай санал бодлоо солилцож ажиллахыг зөвлөж байна.

Шалгаруулалтын эцсийн үнэлгээг гаргахдаа тухайн иргэн хэр идэвх санаачилгатай бүтээлч суралцаж байгааг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Тухайн орон нутгийн ажлын хэсэг иргэдийнхээ сургалтын үйл явцтай улиралд 1 удаа танилцаж, зөвлөмж өгч үйл ажиллагааг нь сурталчилж ажиллахыг хүсье.

**ҮНДЭСНИЙ БИЧГИЙН “ТҮРГЭН УНШИГЧ-2021”
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2021.01.12

Булган аймаг

Зорилго: 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшил, иргэд, суралцагчдын үндэсний бичгийн унших чадварыг дээшлүүлж, хос бичигтэн болох бэлтгэл ажлыг хангуулахад оршино.

Хамрах хүрээ, төрөл:

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид

6-7 дугаар анги

8-9 дүгээр анги

10-12 дугаар анги

2. Төрийн албан хаагчид

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 23-аас 04 дүгээр сарын 20

Бүртгэл: 2021.01.23-аас 2021.04.20-нд Жич: Бүртгэлийн хуудсыг “МОНГОЛ БИЧИГ БУЛГАН АЙМАГ” нүүр номын хуудсаар байршуулна.

Уралдааны даалгавар: Бичмэл, дармал, модон барын бичвэрийг унших

Тавигдах шаардлага:

- Танил бус эхээс үндэсний бичгээр зөв, шударга, түргэн уншина.

- Хоёр удаа уншиж, хамгийн олон үг уншсанаар нь тооцно.

- Хугацааг 1 минутаар тооцно.

Уралдааны үйл явц: 3 үе шаттай явагдана.

Нэгийг даваа: Анги, бүлэг, байгууллага, багийн тэргүүний уншигч шалгаруулна. Үүнийг сургууль, баг, байгууллага бие даан зохион байгуулна. 2021.03.15-ны өмнө /Хугацааг жич мэдэгдэнэ./

Хоёрын даваа: Сумын тэргүүний уншигч суралцагч, тэргүүний уншигч төрийн албан хаагч, иргэдийг сумын ажлын хэсэг шалгаруулж, шалгарсан суралцагч, төрийн албан хаагч, иргэний уншсан бичлэгийг тайлангийн хамт Булган аймгийн Монгол хэлний салбар зөвлөлд хүргүүлнэ. 2021.04.10-ны өдрөөс өмнө /хугацааг жич мэдэгдэнэ./

Гурвын даваа: Аймгийн Түргэн уншигч суралцагч, төрийн албан хаагч, иргэдийг аймгийн “Хэлний бодлогын салбар зөвлөл”-ийн гишүүд шалгаруулна. 2021.04.20-оос өмнө /Хугацааг жич мэдэгдэнэ./

Шалгуур үзүүлэлт:

Үзүүлэлт	Үнэлгээний шалгуур	Дүгнэлт /Хийсэн ажлынхаа үр дүнг оновчтой дүгнэн бичнэ./
Танил бус эхийг зөв, шударгаар хамгийн олон үг уншсан байдал	Тавигдах шаардлагын дагуу зөв шударгаар хамгийн олон үг уншсан бол 10 оноо	
Танил бус эхээс хамгийн олон үг уншсан боловч тавигдах шаардлагын дагуу уншаагүй бол алдаа тус бүрээр 1 оноо тооцож хасах	Танил бус эхээс хамгийн олон үг уншсан боловч уншихдаа гацаж, түгдэрсэн бол 9 оноо	
	Танил бус эхээс хамгийн олон үг уншсан боловч уншихдаа гацаж, түгдрэх, үг орхисон бол 8 оноо	
	Танил бус эхээс хамгийн олон үг уншсан боловч уншихдаа гацаж, түгдрэх, үг орхих, үгийг буруу уншсан бол 7 оноо	

**БУЛГАН АЙМАГ ҮНДЭСНИЙ БИЧГИЙН “САЙХАН БИЧИГТЭН IY”
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2021.01.12

Булган аймаг

Зорилго: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх, Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх” жилийн хүрээнд суралцагч, төрийн албан хаагч, иргэд, монгол хэл, бичгийн багш нарын үндэсний бичгээр сайхан бичих чадварыг дээшлүүлэхэд оршино.

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 20-оос 04 дугаар сарын 20

Оролцох төрөл:

Сайхан бичгийн төрөлд:

- 6-9 дүгээр ангийн суралцагч;
- 10-12 дугаар ангийн суралцагч;
- Насанд хүрэгчид;
- Монгол хэл, бичгийн мэргэжлийн багш;

Бичвэрийн бус төрөлд:

Сонирхсон бүх хүмүүс оролцож болно.

Бичвэр болон бичвэрийн бус төрөлд тавих шаардлага:

Ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн суралцагчдын төрөлд:

“Аялгуу сайхан монгол хэл минь” сэдэвт 120-140 үгтэй эх зохион найруулж бичнэ. Зөв бичиг, цэвэр бичиг, зохион найруулах чадвар, үгийн тоог харгалзан дүгнэнэ.

Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн суралцагчдын төрөлд:

“Үндэсний бичгийг судлахын ач холбогдол” сэдэвт 200-250 үгтэй эх зохион найруулж бичнэ. Зөв бичиг, цэвэр бичиг, зохион найруулах чадвар, үгийн тоог харгалзан дүгнэнэ.

Насанд хүрэгчдийн төрөлд:

“Үндэсний бичиг сурсан миний арга барил” сэдвээр 200-250 үгтэй эх зохион найруулж бичнэ.

Дүгнэх аргачлал

№	Дүгнэх аргачлал	Шалгуур	Оноо
1.	Босоо харьцаа	Үсгийн харьцааг харж алдаа болгоноос 0.2 оноо хасна.	5 оноо
2.	Хөндлөн харьцаа		5 оноо
3.	Налуу харьцаа		5 оноо
4.	Алдаагүй зөв бичих чадвар	Үгийн алдаа болгоноос 0.3 оноо хасна.	30 оноо
5.	Зохион найруулах чадвар	Зохиомж 10 оноо Найруулгын шаардлага 10 оноо Үг хэллэгийн сонголт 10 оноо	30 оноо
6.	Үгийн тоо	Үгийн тоондоо багтсан 3 оноо Үгийн тоог 20 хүртэлх үгээр илүүдсэн болон дутсан 2 оноо Үгийн тоо 20-40 үгээр бага болон их бол 1 оноо Үгийн тоо 40 үгээс бага болон их бол 0 оноо	3 оноо
7.	Тухайн сэдвийн хүрээнд бичсэн байх	Эхийг уншиж агуулга нь сэдэвтэйгээ уялдсан эсэхийг харна.	10 оноо
8.	Эхийн бүтэц /эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй байх/	Эхийг уншиж бүтцийн дагуу хэрхэн бичсэнийг харгалзана.	10 оноо
9.	Цэг, цэглэлийн дүрэм	Бичвэрт дүрмийн алдаагүй бол 2 оноо Алдаа бүрээс /-0.2 оноо/ хасна	2 оноо

Монгол хэл бичгийн мэргэжлийн багш нарын төрөлд:

АЗ хэмжээтэй муутуу болон бичвэрийн бусад материал дээр бийрийн бичлэгээр дараах дуунаас сонгон бичнэ.

1. Үг. Х.Соёмбо, Ая. Д.Цэвээнравдан УГЗ “Булган хангай”
2. Үг. МЗЭ-ийн гишүүн А.Далхжав, Ая. МХЗЭ-ийн шагналт Г.Эрдэнэчулуун “Булган хангайдаа”
3. Үг. Ц. Батбаяр, Ая. МУГЖ А.Энхтайван “Булган нутаг минь”
4. Үг. МУСТА Я.Болдбаатар, Ая. МУГЖ А.Энхтайван “Булган хангай нутаг”
5. Үг. Х.Соёмбо, Ая. О.Бэхбат “Булганы үдэш ”
6. Үг. Ч.Шарав –Арилдий, Ая Ж.Гантөгөлдөр “Булган нутаг”
7. Үг Б.Мөнхбаатар, Ая Б.Атарсайхан “Миний нутгийн шуранхай”
8. Үг. Ая У.Нармандах “Нутаг минь Булганхангай”
9. Үг. Н. Дагвадорж, Ая. Э.Сүхбаатар “Булган аймгийн дуу”
10. Үг. Х. Дугарсүрэн, Ая. Г.Төвшинтөр “Булган хангай”

№	Дүгнэх аргачлал	Шалгуур	Оноо
1.	Ур чадвар	Бичигчийн ур чадварын онцлог гаргасан байдал	14 оноо
2.	Бичгийн хэв	Бичгийн хэвнээс өөрийн онцлог бичлэгийн өнгө аясыг гаргасан байдал	10 оноо
3.	Зөв бичсэн байдал	Алдаагүй бичсэн байдал	8 оноо
4.	Цэвэр бичсэн байдал	Цэвэр бичсэн байдал	8 оноо
5.	Зохиомж	Өгүүлэмж, утга агуулга илэрхийлсэн байдал	10 оноо

Бичвэрийн бус төрөлд:

Булган нутгийн холбогдолтой өөрийн дуртай үг, холбоо үг, шүлгийг арьс, цаас, муутуу, эсгий, даавуу, үйс, мод, чулуу, шил, металл хавтан гэх мэт материал дээр урласан бүтээлээ ирүүлнэ. Уран сэтгэмж, агуулга, дизайн, гүйцэтгэлийг харгалзан дүгнэнэ.

№	Дүгнэх аргачлал	Оноо
1.	Бүтээл нь 2021 онд шинээр хийсэн бүтээл байна.	5 оноо
2.	Өнгө үзэмж	10 оноо
3.	Хийц	12 оноо
4.	Загвар дизайны шийдэл	10 оноо
5.	Зөв бичиг	15 оноо
6.	Утга агуулга	18 оноо
7.	Гүйцэтгэл	30 оноо
Бүгд		100

1-р үе шат: Байгууллага, “Багийн сайхан бичигтэн” шалгаруулна. Байгууллагын ажлын хэсэг тухайн байгууллагын түвшинд удирдамжид заасан ангиллаар 2021 оны 01 дүгээр сарын 20-оос 04 дүгээр сарын 01 хүртэл анхан шатны шалгаруулалтыг зохион байгуулна. Иргэдийн бичвэрийг багийн засаг дарга нар, насан туршийн боловсролын төв, нэгжийн багш хариуцан зохион байгуулна.

2-р үе шат: Сумын ажлын хэсэг нь байгууллага, багаас шалгарсан “Сайхан бичигтэн”-ий ирүүлсэн бүтээлүүдийг 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс 04 дүгээр сарын 15-нд шалгаруулна.

3-р үе шат: Аймгийн тэргүүний сайхан бичигтэн сумаас шалгарсан төрөл тус бүрийн эхний 5 бүтээлийг Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, ажлын хэсэгт 2021 оны 04 дүгээр сарын 15-аас 04 дүгээр сарын 20-ны дотор шалгаруулна.

Шагнал: Ангилал тус бүр

1-р байр 1, Өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр 1, Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр 1, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Аймгийн сайхан бичигтэнд ирүүлэх бүтээлийн хугацаа:

Бичвэр болон бичвэрийн бус төрлийн бүтээлийг Булган аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Монгол хэлний сургалт хариуцсан мэргэжилтэн Л.Намуунтуяа 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 15 цаг хүртэл хүлээн авна.

Жич: Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг эзэнд нь буцаан олгохгүй. Шилдэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргана.

Хавсралт: Дууны үгийг хавсаргав.

**ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ЗААХ АРГА ЗҮЙ, УРЛАН БҮТЭЭХ
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2021.01.12

Булган аймаг

Нэг. Зорилго: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх, Үндэсний бичиг сургах сургалтын орчин бүрдүүлж, заах арга зүйн шинэ санаа, арга технологийг туршин, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хоёр. Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 20

Гурав. Хамрах хүрээ: Төрийн албан хаагчид, иргэд

Дөрөв. Бүтээлийн төрөл

- 4.1. Үндэсний бичиг заах арга зүйн нэгж хичээлийн хөтөлбөр /5-8 цагийн/
- 4.2. Үндэсний бичвэрийн бичлэгийн хэрэглэгдэхүүн бэлтгэх /эвхмэл, таталган, дүрст, бийрийн уран бичвэрүүдээр бичих, унших хэрэглэгдэхүүн боловсруулж оролцох/
- 4.3. Цахим хичээлийн хэрэглэгдэхүүн
- 4.4. Гарын авлага, үндэсний бичиг заах арга зүйн зөвлөмж гэх мэт /Булган аймгийн газар усны нэр, домог, нутгийн дуу, шүлэг, бахархан дуурайх хүмүүсийн түүх, шастир, хөрөг, намтар болон ижил нэр, уламжлалт бичлэгтэй үгс, дүрс ялган бичих үг, таван хошуу малын эдлэл хэрэглэл зэргээр толь бичиг бүтээх, үндэсний өв, соёлын сан хөмрөгийг баяжуулах зургийн цомог бүхий бичвэр гэх мэт/
- 4.5. Олдоц ховор /модон бар, хулсан үсгийн бичвэрүүдийг цуглуулан, сургалтын бүтээлч хэрэглэгдэхүүн бэлтгэх/
- 4.6. Арьс, ноос, металл болон акустик хавтан, давуу, утас, эсгий, үйс, мутуу цаас, мод, чулуу гэх мэт

эко материалуудыг хэрэглэн бүтээл урлах

Тав. Тавигдах шаардлага

- 5.1. Энэ онд шинээр хийсэн бүтээл байна.
- 5.2. Өөрөө боловсруулсан байх
- 5.3. Зөв бичгийн дүрмийн алдаагүй байх
- 5.4. Өнгө үзэмж сайтай байх
- 5.5. Оюуны өмчийн маргаангүй байх /Маргаан гарсан тохиолдолд иргэн өөрөө хариуцна./
- 5.6. Үндэсний бичиг сургах ач холбогдолтой байх
- 5.7 Хийц чанарын хувьд эдэлгээний шаардлага хангасан, дахин хэрэглэх боломжтой байх

Зургаа. Шагналын сан

1-р байр 1, Өргөмжлөл, 500000 төгрөг

2-р байр 1, Өргөмжлөл, 300000 төгрөг

3-р байр 1, Өргөмжлөл, 200000 төгрөг шагналаар шагнаж урамшуулна.

Жич: Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг эзэнд нь буцаан олгохгүй. Шилдэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргана.

ҮНДЭСНИЙ БИЧГИЙН ЗААХ АРГА ЗҮЙ, УРЛАН БҮТЭЭХ УРАЛДААНЫГ ДҮГНЭХ ЗӨВЛӨМЖ

Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулж буй үндэсний бичгийн заах арга зүй урлан бүтээх уралдааны бүтээлийн төрлийн 4.1 дэх Үндэсний бичиг заах арга зүйн нэгж хичээлийн хөтөлбөр /5-8 цагийн/ үнэлэхдээ 5-8 цагийн үндэсний бичгийн нэгж хичээлийн хөтөлбөрийг тооцон үнэлээрэй.

Нэгж хичээлийг үнэлэхдээ дараах 6 үзүүлэлтэд 33 оноо авах шалгуур үзүүлэлтээр дүгнээрэй. Үүнд:

- 1. Суралцагчдын өмнөх төсөөллийн судалгааг авсан байх /5 оноо/**
 - Өмнөх төсөөллийн судалгаа авч, үр дүн, ахицад даалгаврын шинжилгээ хийхэд суралцагчдын 51-ээс дээш хувьд ахиц гарсан бол **5 оноо**
 - Өмнөх төсөөллийн судалгаа авч, үр дүн, ахицад даалгаврын шинжилгээ хийхэд суралцагчдын 50 хүртэлх хувьд ахиц гараагүй бол **2.5 оноо**
 - Өмнөх төсөөллийн судалгаа авсан боловч, үр дүнд боловсруулалт хийгээгүй бол **0 оноо**
- 2. Агуулгын судалгаа хийсэн бол /3 оноо/**
 - Суралцагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт тохируулан агуулгаа оновчтой сонгож, төлөвлөсөн бол **3 оноо**
 - Агуулгын залгамж холбоог ханган, үндэсний өв соёлыг шингээн интеграцчлан заасан бол **2 оноо**
 - Агуулгаа сонгосон боловч нас сэтгэхүйн онцлогт тохироогүй бол **1 оноо**
- 3. Арга зүйгээ судлан хэрэгжүүлсэн бол /5 оноо/**
 - Өөрийн арга зүйг шинээр боловсруулж, туршин хэрэгжүүлсэн бол **5 оноо**
 - Нас сэтгэхүйн онцлогт тохируулан үндэсний бичиг сургах аргад сурган, хэвшүүлсэн бол **3 оноо**
 - Бусдын заах арга зүйг туршиж, хэрэглээ болгосон бол **1 оноо**
- 4. Хэрэглэгдэхүүний судалгаа /5 оноо/**
 - Сургалтын хэрэглэгдэхүүн нь суралцагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт тохирсон, сонирхол татахуйц, өнгө үзэмжтэй, дахин хэрэглэх боломжтой бол **5 оноо**
 - Сургалтын хэрэглэгдэхүүн нь суралцагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт тохирсон боловч, хүртээмж бага, нэг удаагийн хэрэглээ байдлаар хийсэн бол **3 оноо**
- 5. Үнэлгээний судалгаа /5 оноо/**
 - Үнэлгээ нь /PDCA/ загвараар эргэх холбоотой хийж, хамгийн бага гүйцэтгэлтэй даалгаварт арга зүйн санаа боловсруулсан бол **5 оноо**
 - Үнэлгээ нь /PDCA/ загвараар эргэх холбоотой хийсэн боловч, даалгаврын шинжилгээг дутуу хийсэн буюу, хамгийн бага гүйцэтгэлтэй даалгаварт арга зүйн санаа боловсруулаагүй бол **3 оноо**
- 6. Нэгж хичээлийн хөтөлбөрийг сайжруулалт /5 оноо/**
 - Нэгж хичээлийн хөтөлбөрөө сайжруулан боловсруулалт хийж, зөвлөмж, гарын авлага бэлтгэсэн бол **5 оноо**
 - Нэгж хичээлийн хөтөлбөрөө сайжруулан боловсруулалт хийж, аргачлал бичсэн бол **3 оноо**

4.3 Цахим хэрэглэгдэхүүнийг дүгнэх үзүүлэлт.

д/д	Шаардлагын төрөл	Шаардлага
1.	Дуу авианд тавигдах шаардлага: /4 оноо/	<ul style="list-style-type: none"> - Хэт өндөр давтамжтай биш бол 1 оноо - Дууны давтамж нэгэн хэвийн биш бол 1 оноо - Энгийн ойлгомжтой бол 1 оноо - Дуу авианы тусламжтайгаар чухал гэсэн ойлголтуудыг тайлбарласан бол 1 оноо
2.	Зурганд тавигдах шаардлага: /3 оноо/	<ul style="list-style-type: none"> - Тухайн сэдвийн агуулгатай сайтар уялдсан бол 1 оноо - Хэлж буй санаагаа хамгийн товчоор

		илрхийлсэн бол 1 оноо - Өнгөний сонголт, харагдах хэмжээ нь зөв бол 1 оноо
3.	Хөдөлгөөнт дүрсэд тавигдах шаардлага: /3 оноо/	- Тухайн объектод хөдөлгөөн оруулж, төлөв байдлыг сайн илэрхийлсэн бол 1 оноо - Өнгөний зохицол болон сонголт, харагдах хэмжээ нь зөв бол 1 оноо - Дүрсийн хөдөлгөөнийг удирддаг бол 1 оноо
4.	Видео бичлэгт тавигдах шаардлага: /3 оноо/	- Тухайн сэдэв, агуулгатайгаа тохирсон бол 1 оноо - Дүрс бичлэг нь чанартай бол 1 оноо - Дуу авианы хувьд шаардлага хангасан бол 1 оноо
5.	Нэг хуудсанд тавигдах шаардлага буюу дэлгэцийн зохиомжлол: /4 оноо/	- Зураг, видео зэрэг материал хичээлийн тексттэй зохицсон бол 1 оноо - Хичээлийн текстийг дэлгэцэнд бүтнээр нь багтаасан бол 1 оноо - Текстийн хэмжээг 5-8 мөрөөр хязгаарлаж, нэг дэлгэцэнд үгийн тоог тохируулсан бол 1 оноо - Текстийг мөрний уртаар хязгаарлаж, 10 хүртэлх үгийг нэг мөрөнд багтаасан бол 1 оноо - Дэлгэцэн дэх текстэнд 2-оос илүү параграф холиогүй бол 1 оноо

Удирдамжийн 4.2, 4.4, 4.5, 4.6 дахь заалтуудыг удирдамжийн 5 дахь заалтын шалгуураар үнэлнэ.

БУЛГАН НУТГИЙН ДУУНЫ ҮГ

Үг. Х. Соёмбын

Ая. Д.Цэвээнравдан УГЗ

БУЛГАН ХАНГАЙ

Урсгал тунгалаг долгиолох цагаар
Уулс толгод нь цэцэглэсэн
Анхдагч төрдөг хангай минь ээ
Амин заяатай нутаг минь ээ
 Сэвлэг хатаах зөөлөн салхитай
 Сэтгэл нөмрөөсөн алсын бараатай
 Удам нь түүхэндээ босоо хийморьтой
 Унаган нутаг минь Булган хангай даа
Дэлгэр зуны тэнүүхэн цагаар
Дэлхийн хаанаас ч тэмүүлэсэн
Аварга төрдөг хангай минь ээ
Аваас заяатай нутаг минь ээ
 Сэвлэг хатаах зөөлөн салхитай
 Сэтгэл нөмрөөсөн алсын бараатай
 Удам нь түүхэндээ босоо хийморьтой
 Унаган нутаг минь Булган хангай даа
Ургацын түрүү шаргалтах цагаар
Уухад айраг нь чимчгэнэсэн
Баатар төрдөг хангай минь ээ
Багаас жаргаасан нутаг минь ээ
 Сэвлэг хатаах зөөлөн салхитай
 Сэтгэл нөмрөөсөн алсын бараатай
 Удам нь түүхэндээ босоо хийморьтой
 Унаган нутаг минь Булган хангай даа
Тэхийн цайрах уудам талдаа
Өнөтэй өвлийн өнгө нь тодроод
Нартад ганцхан хангай минь ээ
Насны шүтээн нутаг минь ээ

Үг. А.Далхжав

/МЗЭ-ийн гишүүн/

Ая. Г. Эрдэнэчулуун

/МХЗЭ-ийн шагналт/

БУЛГАН ХАНГАЙДАА

Булган хангайн уулсынхаа
Будан мананд омогшин
Буурал мэргэд дээдсийнхээ
Буян заяанд төрлөө би, өслөө би
 Булган хангайдаа
 Хан их уулсынхаа
 Хацар шанаанд ээнэгшин
 Хатан төрмөл ээжийнхээ
 Хантааз хормойд төрлөө би, өслөө би
 Булган хангайдаа
Цантай хяруутай хангайнхаа
Цармын тойрогт цанхаалан
Цайлан хайлан ээжийнхээ
Цацлын сүүтэй төрлөө би, өслөө би
 Булган хангайдаа
 Айраг, тариатай хангайнхаа
 Рашаан булагт ариусан
 Айрхан нуур шиг ээжийнхээ
 Алганы хонхорт төрлөө би, өслөө би Булган хангайдаа

Үг.Ц. Батбаяр

Ая. МУГЖ А. Энхтайван

“БУЛГАН НУТАГ МИНЬ”

Солонгын өнгөт нутаг минь минь
Суу алдрын ундарга минь
Сэнгэнэм айрагны үнэр минь
Сэтгэл хоргодоом ээжий минь
 Заяа холдохооргүй газар минь
 Зөрүү явмааргүй орчлон минь
 Бууж холдохооргүй газар
 Буцаад олдохооргүй нутаг минь
Хөгнө хаан сүслэгтэй нутаг
Хантай Намнангийн оргил минь
Хан түшээ Орхон минь
Хатан түшээ Сэлэнгэ минь
 Заяа холдохооргүй газар минь
 Зөрүү явмааргүй орчлон минь
 Хамгаас түшигтэй уулс минь
 Хорвоог элээмгүй тавилан минь
Бодлын гэгээн нутаг минь
Буурлын түүхтэй хангай минь
Баялгийн эрдэнэс Эрдэнэт минь
Булган тоонот өргөө минь
 Заяа холдохооргүй газар минь
 Зөрүү явмааргүй орчлон минь
 Бууж холдохооргүй газар
 Буцаад олдохооргүй нутаг минь
Хүмүүний заяат нутаг минь
Хайрлан жаргамаар хайрхан минь
Хөгжлийн төлөөх ирээдүй минь
Хамтдаа урагшлах харгуй минь
 Заяа холдохооргүй газар минь
 Зөрүү явмааргүй орчлон минь
 Бууж холдохооргүй газар
 Буцаад олдохооргүй нутаг минь

Үг.МУСТА Я. Болдбаатар

Ая. МУГЖ А.Энхтайван

БУЛГАНХАНГАЙ НУТАГ

Амьсгал зөөлөн салхин сэвшээтэй
Амьдрал тэмцлийн ууган өлгий минь
Алтан соёмбо баатруудын орон
 Алагхан зүрхний дуулал Булганхангай нутаг
 Ай даа Цаст хайрхан уулс тал нь
 Цадиг түүхийн өвийг зузаалсан
 Тэвэрч эрхэлмээр жаргалын орон
 Түүчээ түүхтэй Булганхангай Булганхангай нутаг минь
Нүүдлийн шувууд дуу алдан санадаг
 Нүдэн цэнхэр нүдэн нуур голуудтай
Айргийн амтаар Монголоо гоёсон
Ардынхаа ухаанаар жаргалаа олсон хангай нутаг минь
 Ай даа Цаст хайрхан уулс тал нь
 Цадиг түүхийн өвийг зузаалсан
 Тэвэрч эрхэлмээр жаргалын орон
 Түүчээ түүхтэй Булганхангай Булганхангай нутаг минь
Сумаа тавихад тэнгэрийн салхин эрчилдэг

Суйлж сугсрахад хүний нутаг залбирдаг
Босоо хийморьтой монгол наадмын
Бурхан заяатай миний Булганхангай нутаг минь
 Ай даа Цаст хайрхан уулс тал нь
 Цадиг түүхийн өвийг зузаалсан
 Тэвэрч эрхэлмээр жаргалын орон
 Түүчээ түүхтэй Булганхангай Булганхангай нутаг минь

Үг. Х.Соёмбо

Ая .О. Бэхбат

БУЛГАНЫ ҮДЭШ

Залуу насны минь хайрын дурсамжтай
Захидал шиг нандигнах Булган хот минь
Дурлалаа шингээсэн үдшийн болзоог минь
Дурсаж яваарай Ачуутын гол минь ээ
 Намуухан байна Булганы үдэш
 Найз чиний минь харц дөлгөөхөн байна
 Хос залуус жаргалтайхан алхаад
 Хонгорхон яриа шивнэлдэнхэн байна
 Булганы үдэш
Залуу хотынхоо гэрэл гудамжаар
Заяаны хань чамтайгаа алхах сайхан
Хавар цэцэглэх ногооны үнэртэй
Хайртай хот минь миний Булган
 Намуухан байна Булганы үдэш
 Найз чиний минь харц дөлгөөхөн байна
 Хос залуус жаргалтайхан алхаад
 Хонгорхон яриа шивнэлдэнхэн байна
 Булганы үдэш

Үг. Ч.Шарав –Арилдий

Ая Ж. Гантөгөлдөр

БУЛГАН НУТАГ

Салхи нь хүртэл амьсгал тэлсэн
Сэтгэлд нялхарсан тансаг өлгий
Сүргийн бэлчээр нар хотолсон
Сүүний мялаалгатай Булган нутаг аа
 Эртний түүхт шашдирт мөнхлөгдсөн
 Эгнэгт алдартай буудайн сүлд ээ
 Эгшигт дуундаа жигүүр ургуулсан
 Эртний домогтой Булган нутаг аа
Үзэсгэлэнт уулс нь үүлэнд умбасан
Үлгэр домгийн сүрлэг хангай
Үр жимс нь өнгөөр чимсэн
Үржил шимтэй Булган нутгаа
 Эртний түүхт шашдирт мөнхлөгдсөн
 Эгнэгт алдартай буудайн сүлд ээ
 Эгшигт дуундаа жигүүр ургуулсан
 Эртний домогтой Булган нутаг аа
Золбоо хийморь нь бадарсан дөлтэй
Зон олны жаргалын орон
Зүрх сэтгэлдээ дээдлэн сүслэгдсэн
Заяагаа тэгшилдэг Булган нутаг аа
 Эртний түүхт шашдирт мөнхлөгдсөн
 Эгнэгт алдартай буудайн сүлд ээ
 Эгшигт дуундаа жигүүр ургуулсан
 Эртний домогтой Булган нутаг аа

Дассан сэтгэлийг хайраар өлгийддөг
Босго нь өлзийтэй алтан хангай
Дуудах нэрийг алдраар мөнхөлсөн
Дархан магнай Булган нутаг аа
Эртний түүхт шашдирт мөнхлөгдсөн
Эгнэгт алдартай буудайн сүлд ээ
Эгшигт дуундаа жигүүр ургуулсан
Эртний домогтой Булган нутаг аа

Үг Б. Мөнхбаатар

Ая Б. Атарсайхан

МИНИЙ НУТГИЙН ШУРАНХАЙ

Мэргэн зүүдтэй зөнч ээжийн минь
Сүүгээ өргөдөг бурхан уул аа
Мөнхийн үнэн судар шиг сургаалтай аавын минь
Хиймороо сэргээдэг Булган уул аа
Уртын дууны шуранхай нь
Уулаа өлгийддөг нутгийн минь
Удамт бөхчүүдийн босоо домог нь
Намтрын хойморт мөнхөд дэвээтэй
Удган зүүдтэй уяхан ээжийн минь
Сүслэн залбирдаг удмын уулаа
Уртын дуундаа уярч хайлдаг аавын минь
Авын онгодтой Булган уул аа
Уртын дууны шуранхай нь
Уулаа өлгийддөг нутгийн минь
Удамт бөхчүүдийн босоо домог нь
Намтрын хойморт мөнхөд дэвээтэй
Сайхан айрагтай сэлүүхэн нутгийн минь
Айлынх нь хойморт аяны дугараатай
Адуун сүргээс унага харвах шиг эхлэлтэй
Анхдагч олонтой миний нутаг аа
Уртын дууны шуранхай нь
Уулаа өлгийддөг нутгийн минь
Удамт бөхчүүдийн босоо домог нь
Намтрын хойморт мөнхөд дэвээтэй

Үг. ая . У.Нармандах

НУТАГ МИНЬ БУЛГАН ХАНГАЙ

Орхон Сэлэнгэ мөрөндөө шувууд нь жиргэх янзтай
Ойр холын бэлтчээртээ адуу малаар баяхан
Онгон ногоон байгальдаа амьтад нь амь нэгтэй
Орон орноос онцгойхон нутаг минь Булган хангай

Уран тогоо уулынхаа энгэрт нүдэн нууртай
Ухваас баялгийн ундаргатай Эрдэнэт сайхан уултай
Ухаант ардаа угаасан рашаан булгын эмтэй
Уйлуулж, дуулуулж, өхөөрдөх нутаг минь Булган хангай

Хөхрөх уулсын даваагаар алсыг заах замтай
Хангай хөндийн цээжиндээ мөнхөд сийлсэн нэртэй
Хүмүүн ардын залгамжилсан голомт үрсэд нь үлдсэн
Хүй хүйгээр холбоотой нутаг минь Булган хангай

Уран тогоо уулынхаа энгэрт нүдэн нууртай
Ухваас баялгийн ундаргатай Эрдэнэт сайхан уултай

Ухаант ардаа угаасан рашаан булгын эмтэй
Уйлуулж, дуулуулж, өхөөрдөх нутаг минь Булган хангай

Найргаар нутгаа таниулсан яруу хөвгүүд өсгөсөн
Наадмаар цолоо дуудуулсан халхын бөхөө төрүүлсэн
Хашир буурлын сургаалтай газар эх мину
Хан эцгээс минь голомттой нутаг минь Булган хангай

Үг. Н. Дагвадорж

Ая . Э. Сүхбаатар

БУЛГАН АЙМГИЙН ДУУ

Анхдагч бүхний ариун өргөө
Алдарт баатруудын ахуй нутаг
Амгалан энхийн түүхт газар
Ачтай хишигтэй алтан нутгаа
 Сайн үйлсийн ундраа болсон
 Сайхан бүхний уриа болсон
 Булган аймаг буянтны нутаг
 Буман олны жаргалын өлгий
Таван эрдэнээр талаа бүрхсэн
Тариа будаагаар газраа дүүргэсэн
Эрдэм ухаанаар хүнээ чимсэн
Энгүй тансаг ариун нутгаа
 Сайн үйлсийн ундраа болсон
 Сайхан бүхний уриа болсон
 Булган аймаг буянтны нутаг
 Буман олны жаргалын өлгий
Сансар огторгуйд нэрээ дуурсгасан
Саруул ирээдүйд хүчээ шавхсан
Ургах нарны гэгээн туяатай
Уудам цэлгэр хангай нутгаа
 Сайн үйлсийн ундраа болсон
 Сайхан бүхний уриа болсон
 Булган аймаг буянтны нутаг
 Буман олны жаргалын өлгий

Үг. Х. Дугарсүрэн

Ая. Г. Төвшинтөр

БУЛГАН ХАНГАЙ

Зүүдэн бүүвэй ээжий минь
Залбирч сүүгээ өргөсөн
Зүрхэнд мөнхийн гэрэлтэй
Булган хангай уул минь
 Зүйлийн хөндийн цэцэгс нь
 Сувдан шүүдэрт эрхэлсэн
 Зоргоор дуулан жаргамаар
 Наран хээтэй нутгаа
Буцаад ирэхэд ээжийн сүүтэй
Булган хангай нутаг минь уу зээ
Хангал хүлэг нь нутаг амьтай
Хаан суудалт цэнхэр хангай

**“ҮНДЭСНИЙ БИЧИГ- БИДНИЙ БАХАРХАЛ” СЭДЭВТ
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2021.01.12

Булган аймаг

Нэг. Зорилго: “Үндэсний бичиг соёлын өдөр”-ийг угтан “Үндэсний өв, бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх” жилийн аяны хүрээнд төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг сорих, түүний хэрэглээг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ: Төрийн албан хаагчид

Гурав. Хугацаа: 2021 оны 3 дугаар сарын 25- аас 4 дүгээр сарын 20

Дөрөв. Тэмцээний төрөл

- 4.1. Монгол бичгээр унших /Багийн бүх гишүүд/
- 4.2. Монгол бичгээр бичих /Багийн бүх гишүүд/
- 4.3. Монгол бичгийн цахим бичвэр /Багийн 1 гишүүн/
- 4.4. Багийн ахлагч нарын даагавар /Өгүүлбэр бүтээх/
- 4.5. Гэрийн даалгавар /Биет бус өв, соёл, түүхийн дурсгалыг судлан сурталчлах зорилго бүхий гарын авлага бэлтгэсэн байна./

Тав. Уралдааны үйл явц

Уралдааныг 3 үе шаттай зохион байгуулна.

Нэгийн даваа. Байгууллагын “Үндэсний бичиг- Бидний бахархал” сэдэвт уралдаан болно. /2021.03.25-2021.04.10/

Хоёрын даваа. Сумын “Үндэсний бичиг- Бидний бахархал” сэдэвт уралдаан болно. Сумын ажлын хэсэг шалгаруулж, шалгарсан байгууллагын мэдүүлгийг аймгийн ажлын хэсэгт 2021.04.15-нд ирүүлнэ.

Гурвын даваа. Аймгийн “Үндэсний бичиг- Бидний бахархал” сэдэвт уралдаан болно. Үүнийг аймгийн ажлын хэсэг шалгаруулна. Хугацаа 2021.04.16-2021.04.20

Зургаа. Багийн бүрэлдэхүүн, түүнд тавих шаардлага

- 6.1. Баг 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 6.2. Багууд жигд таних тэмдэг, үндэсний хувцастай байна.
- 6.3. Аймагт оролцох багийн мэдүүлгийг 2021 оны 4 дүгээр сарын 16 -нд аймгийн ажлын хэсэгт ирүүлнэ. Хугацаа хоцорсон мэдүүлгийг хүлээж авахгүй, мэдүүлэг өгөөгүй бол уралдаанд оролцуулахгүй.
- 6.4. Цахим бичвэрийн даалгавар гүйцэтгэх ажилтан өөрсдийн зөөврийн компьютерт үндэсний бичгийн фонд суулгасан байна.
- 6.5. Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-ийн оролцох багт Монгол хэл, уран зохиол, бага, түүх нийгмийн ухааны багш нарыг оролцуулахгүй.
- 6.6. Оролцогч төрийн болон аж ахуй нэгж байгууллагууд хаягаа Үндэсний бичгээр бичсэн байх ба фото зургийг авч ирнэ. /Оноонд нөлөөлнө/
- 6.7. Гэрийн даалгавар нь 2021 онд шинээр хийсэн, Булган аймгийн биет бус өв, үндэсний өв, соёлыг өвлөн тээгчдийн сурталчилсан бүтээл байна.

Долоо. Шагналын сан

1-р байр: Өргөмжлөл, 500000 төгрөг

2-р байр: Өргөмжлөл, 300000 төгрөг

3-р байр: Өргөмжлөл, 100000 төгрөг

Энэ үеэр үндэсний бичгээр хэвлэгдсэн ном, бичвэрийн үзэсгэлэн гаргана.